

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн арван зургадугаар хуралдааны тэмдэглэл /2017-12-21/

Үндэсний зөвлөлийн арван зургадугаар хуралдаан 2017 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 15 цагт Төрийн ордны “Нутгийн удирдлагын танхим”-д эхлэв.

Хуралдаанд Ерөнхий сайдыг орлож Ерөнхий сайдын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Энх-Амгалан, Сангийн сайдын орлож Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын дарга Г.Түвдэндорж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдыг орлож Уул уурхайн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Д.Дамба, Байгаль орчин аялал жуулчлалын сайдыг орлож хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Б.Саран, Үндэсний статистикийн хорооны дарга А.Ариунзаяа, Монгол улсын ерөнхий аудитор Д.Хүрэлбаатарыг орлож, Стратегийн бодлогын газрын мэргэжилтэн Б.Өлзий, Авлигатай тэмцэх газрын даргыг орлож Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Т.Баярхүү, мэргэжилтэн Л.Тэрбиш, Төв аймгийн Засаг дарга Э.Батжаргал, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Н.Алгааг орлож гүйцэтгэх захирал Д.Энхболд, Эрдэнэт үйлдвэр ХХК-ны эдийн засаг, маркетингийн хэлтсийн орлогч дарга Д.Галбаатар, Монголросцветмет ХХК-ийн тэргүүлэх мэргэжилтэн М.Болдбаатар, Монполимет ХХК Группын гүйцэтгэх захирал С.Энхтуяа, Энержи ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Батцэнгэл, төрийн байгууллагын харилцаа, зөвшөөрөл хариуцсан захирал Б.Сугармаа, Оюутолгой ХХК-ны ерөнхийлөгч Андрию Вүүдлэйг орлож Хамтын ажиллагааны ахлах менежер Т.Мөнхбат, Петрочайна дачин тамсаг ХХК-ны ерөнхий захирал С.Мэргэнсодыг орлож ерөнхий нягтлан бодогч Д.Болормаа, Нээлттэй нийгэм форумын захирал П.Эрдэнэжаргалыг орлож, ТАН эвслийн зохицуулагч Д.Эрдэнэчимэг, Хүний эрх хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож, Хил хязгааргүй алхам ТББ-ийн тэргүүн Н.Баярсайхан, Монголын байгаль эхийн аврал сан ТББ-ийн тэргүүн Н.Наранцэцэг, Хөвсгөл далайн эзэд ТББ-ийн тэргүүн Б.Баярмаа, Ил тод сангийн тэргүүн Д.Цэрэнжав, Миний монголын газар шороо ТББ-ын тэргүүн Б.Болдбаатар, Монголын Байгаль орчны иргэний зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн Ю.Дэлгэрмаа нар оролцов. Хуралдаанд Үндэсний зөвлөлийн 30 гишүүдээс 23 гишүүд оролцож ирц 76,6 хувьтай байв.

Мөн хуралдаанд КэйПиЭмЖи Франц түншлэлийн партнер Марк Эберт, захирал Г.Соёлмаа, Монгол талын партнер Жавхлан нар ирсэн байна. Ерөнхий сайдын ажлын албаны референт Гандөл, шинжээч Цэрэнжүрмэд, Татварын ерөнхий газрын байцаагч Ж.Батцэнгэл болон Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг, Мэдээлэлийн технологийн зөвлөх Г.Ганбат нар оролцов.

Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн арван зургадугаар хуралдааныг Ерөнхий сайдын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Б.Энх-Амгалан удирдан явуулав.

Б.Энх-Амгалан: Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Ерөнхий сайд маань ажил ихтэй байгаа тул оролцож амжсангүй, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн хуралдааныг би удирдан явуулна. Уул уурхай хариуцлагатай, шударга, ил тод нээлттэй, зөв уул уурхай байх ёстой гэсэн бодлогыг барьж байна. Түүнчлэн хамгийн чухал нь уул уурхай нь хүрээлэн байгаа орчинд ээлтэй, аюулгүй байх ёстой. Ерөнхий сайд хэлсэн үгэндээ, лиценз, тусгай зөвшөөрөл олгох ажлыг ил тод шударга байлгана, аливаа хариуцлагагүй байдалтай хатуу тэмцэнэ гэдгээ мэдэгдсэн. Энэ нь Засгийн газрын зүгээс, Ерөнхий сайдын зүгээс баримтлах чиг баримжаа байх юм.

Хуралдааны журам ёсоор хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулснаар хурал эхлэв.

Б.Энх-Амгалан: Хөтөлбөрийн дагуу Монгол улсын ОУИТБС-ын 2016 оны буюу 11 дүгээр тайланг Кэй ПиЭмЖи аудитын захирал Г.Соёлмаа танилцуулна.

1. ХЭЛЭЛЦСЭН НЬ: Монгол Улсын ОУИТБС-ын 2016 оны буюу 11 дүгээр тайланг хэлэлцэж, батлах тухай

Г.Соёлмаа: Сайн байцгаана уу, Ерөнхий сайдын ахлах зөвлөх Энх-Амгалан гуай болон хүрэлцэн ирсэн гишүүдийн амар амгаланг айлтгая. Манай компани нь ОУИТБС-ын 2016 оны буюу 11 дүгээр нэгтгэл тайланг Францын салбартайгаа хамтран хийж гүйцэтгээд, тайлангаа хүлээлгэн өгөхөөр хүрэлцэн ирээд байна. Би тус компанийн ерөнхий захирал, Франц талын партнер Марк Эверст, Монгол талын партнер Жавхлан нартай хамт ирсэн.

Бид явцын тайлангийн хүрээнд гурван үндсэн зүйлийг танилцуулна. Үүнд, нэгдүгээрт тайлангийн явцад нэгтгэлд олж илрүүлсэн зүйл, олон улсын баталгаажуулалттай холбоотой асуудлыг тайландаа хэрхэн тусгасан талаар, гуравдугаарт тайлангийн хүрээнд гарсан зөвлөмжүүдийг дурдах болно.

Манайх нэгтгэлийг хийхдээ ажлын хэсэгтэй зөвшилцсөний дагуу материаллаг босгыг тогтоосон. Мөн ажлын хэсгийн хүсэлтээр улсын хэмжээнд болон орон нутгийн хэмжээнд гэсэн тус тусдаа босго тавьсан. Түүвэрт улсын хэмжээнд 50 саяас дээш, орон нутгийн хэмжээнд 30 саяас дээш төгрөгийн орлого оруулсан компанийг сонгож авсан. Засгийн газар 2016 онд нийтдээ 2079 компаниас орлого хүлээн авсан гэж бүртгэгдсэн. Эрсдэлд суурилсан аргачлал болон Засгийн газрын тайлагнасан гол орлогын дүнгүүдийг харгалзан үзсэнээр эдгээр компаниудаас материаллаг босго давсан, өндөр эрсдэлтэй 213 компанийг тулган баталгаажуулалтад сонгож авсан. Эдгээр компаниуд Засгийн газрын хүлээж авсан орлогын 95,6 хувийг эзэлж байна. Анхны тайлангаар Засгийн газар 1,16 их наяд төгрөгийн орлогыг компаниудаас хүлээн авсан гэж тайлагнасан харин компаниуд 1,06 их наяд төгрөг төлсөн гэж тайлагнасан. Засгийн газар компанийн хоорондох анхны зөрүү 105 тэрбум төгрөгийн зөрүү гарсан. Ингээд Засгийн газрын байгууллагууд болон компаниуд руу нэмэлт мэдээллийн маягт явуулж, мэдээллийг авснаар 90 тэрбум төгрөгийн залруулга хийгдэж, нэгтгэлийн дараах зөрүү 74 сая төгрөг болсон. Бид нэгтгэлийн тайлангаар гарсан шийдвэрлэгдээгүй зөрүүг авч үзэхэд, 2014 онд 581 сая төгрөг, 2015 онд 112 сая төгрөгийн зөрүү шийдвэрлэгдээгүй байсан бол энэ жил буюу 2016 оны тайлангаар 74 сая төгрөгийг шийдвэрлэгдээгүй зөрүү гарсан байна.

Нэгтгэлийн зөрүү дээр гарсан нийтлэг шалтгааныг дурдвал, Засгийн газар болон компаниуд мөнгөн бус хандивын дүнг хөрвүүлэхдээ өөр өөр аргачлалтыг хэрэглэж байгаа учраас зөрүү гарч байна, зарим компаниуд ОУИТБС-ын тайланг ирүүлэх хууль эрх зүйн шаардлага байхгүй гэж үзсэнээс тайланг ирүүлэхгүй байх, аймаг дүүргээс мэдээллийг шаардсан боловч хангалттай мэдээлэл авч чадаагүй. Компаниуд цахим тайланд тайлагнаагүй, төлбөрөө илүү тайлагнасан, төлбөрийн буруу төлбөрийн ангилал мэдээлсэн, буцаагдсан төлбөрийг компанийн тайланд тохируулаагүй, өөр компанийн өмнөөс төлсөн төлбөрөө тайлагнасан, төлбөрүүд цэвэр дүнгээр бичигдсэн, өмнөх жилийн төлбөрийг энэ онд оруулсан, олборлох үйл ажиллагаанд хамааралгүй төлбөрүүдийг тайлагнасан гэх мэт. Засгийн газрын

орлогыг бүрдүүлж байгаа хамгийн их төлбөр төлсөн 15 аж ахуйн нэгжийг нэгтгэн гаргасан. Үүнд, Оюу толгой 36%, Эрдэнэт Үйлдвэр 16%, Петрочайна дачин тамсаг 14 % гэх мэт нийт орлогын 86 хувийг бүрдүүлсэн байна. Мөн нийт орлогын урсгалыг харуулвал, нийт орлогын 24 хувийг АМНАТ, ААНОАТ 21%, газрын тосны орлого 12 хувийг тус тус бүрдүүлжээ. Бид нэгтгэлийн хийсэн ажлын үр дүнг товчхон танилцууллаа, өмнө нь ОУИТБС-ын Ажлын хэсгийн хуралдаанаар дэлгэрэнгүй танилцуулсан. Дараагийн хэсэг бол ОУ-ын баталгаажуулалтын талаар тусдаа бүлэг болгож авч үзсэн. 2016 онд батлагдсан ОУИТБС-ын ОУ-ын стандартын хэрэгжилтэд ОУНБДнГ-аас баталгаажуулалт хийгдэж, үр дүнг 2017 оны 1 сард үр дүнг танилцуулсан байна. Дараагийн баталгаажуулалт нь 2018 оны 1 сард гэж төлөвлөсөн байгаа юм байна. Бид тайландаа ОУИТБС-ын стандарт хэрхэн хэрэгжиж байгаа талаар судалж, оруулсан. Хангалтгүй үнэлгээ авсан ажлуудын хүрээнд ямар ажил хийгдсэн гэдгийг улаанаар тэмдэглэн харуулсан. Тухайлбал, тусгай зөвшөөрлийн гэрээ болон бүртгэл гэдэг дээр тодорхой хэмжээний ахиц гарсан байсан. Үүнийг тайлангийн 5 дугаар зүйл дээр тусгаж өгсөн. 2016 онд олгосон, шилжүүлсэн лицензийн мэдээлэл, хууль тогтоомж, дүрэм журам мөрдөгдөөгүй байдал, нэгтгэлд хамрагдсан 213 компаниас 109 компанийн 251 өргөдлийн огноог оруулсан. Энэ нь нийт орлогыг 77 хувийг эзэлж байна. Мөн бүтээгдэхүүн хуваах гэрээний солбилцлын цэгүүдийг оруулж өгсөн гэх мэтчилэн ажлуудыг тусгасан. Мөн төрийн оролцоо гэдэг дээр хангалтгүй гэсэн үнэлгээ авсан байсан. Тайлангийн 5.4.2-5.4.4 хэсгүүдэд мэдээллийн оруулсан. Энэ ажлын хүрээнд Эрдэнэс Монгол ХК болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай уулзалт зохион байгуулсан, Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдтэй тус бүрчлэн уулзаж, ярилцсан. Тайланд хуримтлагдсан ашиг, хөрөнгө оруулалтын талаарх дүрэм, журам практикийг тусгах зөвлөмжийн дагуу дүнгүүдийг оруулсан. Төрийн өмчийн эзэмшил, өөрчлөлт, олгосон зээл зээлийн баталгаа гэсэн мэдээллүүд төсвийн шинжтэй зарцуулалт зэргийг зөвлөмжийн дагуу тайланд оруулсан. Мөн төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээс хийсэн гүйлгээг тодруулж, тайлангийн 5.4.5 хэсэгт оруулсан. Мэдээллийн чанарыг тайлангийн 3.3.4 хэсэгт үнэлж мэдээлэл ирүүлээгүй компаниудын нэрийг дурдаж оруулсан байгаа. Мэдээллийг чанарыг үнэлэхэд нийт нэгтгэлд хамрагдсан 213 компаниас 14 компани сайн, 34 компани дунд үлдэх 165 компани муу гэсэн үнэлгээг авсан байна.

2016 оны нэгтгэл тайлангийн хүрээнд дараах зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд, төрийн байгууллагуудаас тайлагнасан мэдээллийг баталгаажуулах журмыг амжилттай хэрэгжүүлэх ажлыг ҮАГ-тай хамтран зохион байгуулах, ОУИТБС-ын ач холбогдол болоод ОУИТБС-ын мэдээллийг бэлтгэдэг Засгийн газрын агентлагуудын хамтын ажиллагааны ач холбогдлыг таниулах ажлын төлөвлөгөөг Үндэсний зөвлөлөөр батлуулах, ТӨААН-үүдтэй холбоотой ОУИТБС-ын стандартын тухайлсан шаардлагуудын талаар сургалт зохион байгуулах, гарын авлага бэлтгэх гэх мэтээр ТӨААН-үүдийн чадавхийг бэхжүүлэх, Цахим тайлангийн системд НӨАТ-ын дүнг хүлээн авагч тус бүрээр буюу Татварын алба болон Гаалийн албанд төлөгдсөн дүнгүүдийг хүлээн авагч байгууллагууд тус тусдаа тайлагнах боломжтойгоор, НӨАТ төлөгч компаниуд салгаж тайлагнах боломжтой байхаар шинэчлэх, ЗГ-ын түвшинд аливаа нэг аж ахуйн нэгж олборлох үйлдвэрлэлээс эсвэл өөр бусад бизнесийн үйл ажиллагаанаас олсон орлогын урсгалыг хооронд нь ялгаж, ангилах горимыг хэрхэн хэрэгжүүлэх талаар авч үзэх, ОУИТБС-ын стандартаар шаардсан наад захын шаардлагуудад нийцсэн мэдээллийг олон нийт авах боломжийг бүрдүүлэх үүднээс тусгай зөвшөөрлийн кадастрын мэдээллийг сайжруулах, Үндэсний зөвлөл энэ

асуудлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд тавьж, хүчин төгөлдөр байгаа Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг олон нийтэд ил тод болгох, орлогын үрсгалыг төслийн түвшинд задлан харуулахын тулд боломжтой нөхцөлд орлогын үрсгалыг төслийн түвшинд хэрхэн ялгах талаар авч үзэх нь зүйтэй гэсэн зөвлөмжүүдийг өгч байна. Түүнчлэн олон талт ажлын хэсгийн зүгээс дараах зөвлөмжүүдийг өгсөн. Үүнд, ОҮИТБС-ын анхны тайланг ирүүлээгүй, цаашлаад Хараат бус хянагч-нэгтгэгчийн шаардсан мэдээллийг танилцуулаагүй эсвэл аудитлагдсан тайлангаа ил тод болгоогүй компаниудад хариуцлагын арга хэмжээг нэмэгдүүлэх, гар аргаар уул уурхайн олборлолт хийх үйл ажиллагааг албажуулах зорилготой Засгийн газрын 151 дүгээр тогтоолоор батлагдсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын хэрэгжилтийг сайжруулах, гэрээний ил тод байдлын талаархи ОҮИТБС-ын стандартуудын хэрэгжилтийг сайжруулах, холбогдох эрх зүйн орчинг бүрдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. /Танилцуулгыг хавсаргав/

Б.Энх-Амгалан: За баярлалаа, тайлантай холбогдуулан санал ,зөвлөмжөө өгөхийг гишүүдээс хүсье.

Н.Баярсайхан: Баярлалаа, ТӨК-ууд олон охин компани байгуулсан байдаг. ТӨК-уудын тухай мэдээллийг тайланд тусгай бүлэг болгож оруулсан гэж ойлголоо. Мон-Чех-Уран гэдэг компанийн 51 хувийг төр эзэмшдэг юм бол үлдэх хувийг хэн эзэмшиж байна гэдгийг ил болгох боломж байна уу. Гэрээний ил тод байдлын талаарх эрхзүйн орчныг сайруулах талаар зөвлөмж өгсөн байна. Эрхзүйн орчин гэдэг нь яг юуг хэлж байна вэ гэдгийг тодорхой болгомоор байна, үүнийг тодруулж өгнө уу.

Партнер Марк: ТӨК-ын бусад эзэмшлийн талаарх мэдээллийг авахдаа төрийн өмчийн хувийг ирүүлэхийг хүссэн, бусад эзэмшигчийн талаарх мэдээллийг дараа жилийн тайландаа оруулах нь зөв юм. Дараагийн асуудлын хувьд, ОТАХ-ын зөвлөмж нь манай зүгээс өгч байгаа зөвлөмж биш, та бүхний хүсэлтээр оруулсан зөвлөмж юм.

Д.Эрдэнэчимэг: Тайланг хийсэн компанидаа баярлалаа, 11 дүгээр сард хуралдсан Ажлын хэсгийн хурлаар нилээд олон санал өгсөн, үүний дагуу ажилласан нь харагдаж байна. Ажлын хэсгийн хуралдаанаар МХЕГ-аас тайлан гаргаагүй компаниудад арга хэмжээ авч ажиллаж байгаа гэсэн, энэ талаарх мэдээллийг тайланд оруулахаар тохирсон. Энэ талаарх мэдээлэл яагаад ороогүй вэ? мэдээлэл өгөх боломжгүй байсан уу? Тайлан анхнаасаа англи хэл дээр бэлтгэгдэн монгол хэл дээр орчуулж байгаа гэсэн. Хэрвээ зөрүү гарвал англи тайлангаа барина гэж байгаа. Ажлын хэсгийн хуралдаанаар танилцуулж байсныг бодвол орчуулга сайжирсан байна, гэхдээ зөрүү гарахыг үгүйсгэхгүй. Тайланг хэнд зориулж бэлтгэж байгаа гэдгээ эргэж хармаар байгаа. Англи хэл дээр бэлтгээд ОУ-ын газарт явуулах гээд байгаа юм уу, эсвэл монгол хэл дээр бэлтгээд иргэдээ мэдээллээр хангах гээд байна уу? Энэ асуудал дахин дахин яригдаж байна. Иймд Үндэсний зөвлөл ярилцаад хараат бус нэгтгэгчид чиглэл өгмөөр байна. Зөвлөмжүүд нилээд ерөнхий байна, санал нийлж байна. Ажлын хэсгийн хуралдаанаар хийсэн танилцуулгад төслөөр тайлагнах зөвлөмж өгсөн байсан, энэ нь ерөнхий байсан тул нарийвчлах санал өгсөн. Харин энэ зөвлөмжөө тайлангаас хассан байна. Нарийвчилж оруулах боломжгүй болохоор зөвлөмжөө хасч болох уу? Ер нь ОУНБДНГ-аас улс болгон төслөөр тайлагнах боломжгүй боловч АМНАТ болон тусгай зөвшөөрлийн төлбөр, орон нутагт төлсөн

төлбөр гэх мэт ялгах боломжтой төлбөрүүдээсээ эхлээд төслөөр тайлагнах тайлангаа үе шаттайгаар хэрэгжүүлэхийг зөвлөж байгаа. Энэ зөвлөмжийг оруулахыг хүссэн боловч бүр хассан байна. Дараагийн асуудал бол тайлангийн 5 дугаар зүйл дээр байгаа Бүтээгдэхүүн хуваах гэрээний талаарх дүгнэлт буруу байна. Маягт өөрчлөгдсөнөөр ил тод болсон гэсэн байна. Харин шинэ загвараас нууцлалын заалтыг хассан, хэрэгжихгүй байна гэсэн дүгнэлт оруулахыг хүссэн.

Б.Энх-Амгалан: Өөр асуулт, санал байна уу? Тайланд хамгийн өндөр татвар төлсөн компаниудын жагсаалтыг харуулсан байна. Энэ нь тайлангаас харах гол үзүүлэлт юм. Хамгийн их татварыг Оюутолгой, Эрдэнэт үйлдвэр, Петродайчин тамсаг компаниуд хамгийн их татварыг төвлөрүүлсэн байна. Компани бүрт асуудал байгаа, асуудлыг засуулах замаар ажиллана. Хэн хэндээ харилцан ойлголцох зарчмаар, хуулийн хүрээнд зохицуулахыг хичээнэ.

За хариултаа өгөх болж байна уу, бид санхүүгийн асуудлыг шийдвэрлэх ёстой байгаа.

Т.Мөнхбат: Төсвийн тухай хуультай холбоотой компаниудын төлсөн татварын тодорхой хэсгийг орон нутагт үлдээх асуудал ажлын хэсгийн хурал дээр яригдаж байсан, энэ талаар тайлангийн зөвлөмжид тусгагдсан уу? Энэ асуудал нилээд яригдаж байгаа, энэ талаар зөвлөмжинд тусгаж өгвөл сайн байна.

Ж.Батжаргал: Тайланг харахад санхүүгийн тайлангийн нэгтгэл маягтай юм харагдаад байна. Бид Нягтлан бодох бүртгэлийн тусдаа хуультай, гаднын байгууллагаар аудит хийлгээд байх шаардлагагүй санагдана. Харин байгаль орчны үнэлгээ, дүн шинжилгээ судалгаа зөвлөмж дүгнэлт гаргуулахаар бол байж болмоор байна. Орон нутагт аж ахуйн нэгжүүд нь орон нутагт харъяалалгүй, Улаанбаатар хотын дүүрэг, томоохон нь ТЕГ-т хамааралтай байгаа. Орон нутагт газар, үс ашигласны төлбөр л төлж байна, иймд бүртгэлийн асуудлыг шийдвэрлэмээр байна. Хөдөө орон нутаг, тухайлбал Заамарт баахан алт олборлочихоод Улаанбаатар хотын нэг дүүргийн үйлдвэрлэл дээр л нэмэгддэг. Санхүүгийн тайлан баланс ингэж гарч байгаа, орон нутгийн удирдлагаас компаниуд хол байгаа бүртгэлийн гажуудал байна. Тухайн бүтээгдхүүнийг ямар үнэ цэнээр гарч байгааг хянах жишиг үнэтэй болмоор байна. Ийм биш болохоор зардал нэмэгдэх хандлагатай байдаг. Тогтвортой орлогын тодорхой хувийг орон нутагт байлгамаар байна. Ингэхгүй болохоор зөвхөн байгалийн нөөц ашигласны татвараас өөр орлого орон нутгийн төсвийг бүрдүүлж байгаа учраас орон нутаг өсөж, дэвжиж чадахгүй байна. Эдгээр саналуудыг тайландаа тусгаж, зөвлөмж болговол цаашдаа хэрэгтэй болов уу гэсэн саналтай байна.

Б.Энх-Амгалан: Баярлалаа, Бид олон улсын санаачилгад нэгдэж орсон учраас тайланг заавал гаргах болж байгаа. Олон улсын өмнө хүлээсэн үүргийн дагуу хурлаа хийж, тайланг хэлэлцэж байна. Засгийн газар үүргээ биелүүлж, жил бүрийн төсөвт тодорхой мөнгө суулгаж, энэ ажлыг хийлгэж байгаа.

Д.Галбаатар: ОУИТБС-ын байгууллага олон улсын жишигт нийцэж ажиллаж байгаа гэхдээ боловсронгуй болгох шаардлагатай зүйлс бий. Тайланд тусгахгүй

байгаа маш олон асуудал байна. Эрдэнэт үйлдвэр байгуулагдсан цагаасаа хойш өнөөг хүртэл өөрийн хөрөнгөөр нийгмийн олон цехүүдийг санхүүжүүлэн ажиллаж байна. Тухайлбал, соёлын ордон, спортын ордон, пионерийн зүслэн зэрэг 10 гаруй цехийг байгуулан ажиллуулж байна. Дээрх зардалд жилдээ 70 гаруй тэрбум төгрөг, хотын төсөвт 16 тэрбум төгрөг төвлөрүүлж байна. Эдгээрийг компанийн нийгмийн хариуцлагын тайланд оруулдаг болмоор байна. Хоёрдугаарт, бид олон нийгмийн цехүүд ажиллуулах нь зөв ч юм үү, буруу ч юм үү. Бид бизнесийн байгууллага, бизнест ганц л хууль үйлчилдэг тэр нь ашиг. Хэрвээ АМНАТ-ын тодорхой хувийг орон нутагт өгдөг хууль байсан бол бид татвараа өгөөд Эрдэнэт өнөөдөр хангалттай сургууль, цэцэрлэгтэй байх. Харин дараа нь бидний өгсөн мөнгийг юунд зарцуулсан бэ гэж тайлагнавал энэ нь бодит байдалд илүү нийцнэ. Бид олон улсын мэдлэг туршлагыг хэрэглэх гэж байгаа бол зөв хэрэглэмээр байна. Бас нэг жишээ. Одоо үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол, шимтгэл гэж тооцож байна, олон улсад үүнээс олон төрлийн хорогдол тооцож байна. Тухайлбал, байгалийн нөөцийн хорогдол гэдэг зүйл, Оюутолгойд байгаа. Өнөөдөр байгалийн нөөцийн хууль гарах гэж байна, тэнд байгалийн нөөцийн хорогдодлыг оруулах хэрэгтэй байна. Төр хөрөнгөө гаргаад хайгуул хийчихсэн байж яагаад заавал 51 хувь байх ёстой юм, яагаад 75 эсвэл 10 байж болдоггүй юм бэ? Бид нөөцөө үнэлдэг аргачлалаар үнэлчихвэл нөөц нь дүрмийн санд суучихна. Үнэгүй байгаа байгалийн баялагийг үнэтэй болгох тухай Ерөнхий сайд ч ярьж байгаа, тэгж чадвал байгалийн абялгийн үнэлгээ зөв болно шүү дээ. Түүнчлэн оюуны өмч үнэлэгдэхгүй байна. Оюутолгой менежмент хийсний төлөө шимтгэл авч байгаа, хөрөнгө босголоо, 6 хувийг авч байна гэтэл манай үйлдвэрийн 16 сая тонн хүдэр боловсруулах ТЭЗҮ-г Оросын 400 гаруй институт хамтран хийснээс хойш, манайхан өнөөдөр 32 сая тонн болтол нэмэгдүүлээд ТЭЗҮ хийчихээд байна гэтэл энэ оюуны өмч ерөөсөө үнэлэгддэггүй. Энэ зүйлүүдийг зөв зүйтэй болгоод өгвөл бид уул уурхайгаас хүссэн зүйлээ авч чадна. Эрдэнэт үйлдвэр өнөөдөр 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын болон орон нутгийн төсөвт 575 тэрбум төгрөг төвлөрүүлнэ, Орхон аймгийн аж үйлдвэрийн бүтээгдхүүний 93 хувь, орон нутгийн төсвийн 90 гаруй хувийг бүрдүүлж байна. Бид өмнө нь орон нутгийн төсөвт төлсөн төлбөрийн 10 хувийг суманд, 20 хувийг аймагт үлдээх тухай Ашигт малтмалын тухай хуулинд тусгах талаар Төсвийн байнгын хорооны төлөөлөлтэй ярьж байсан. Байгалийн нөөцийн хорогдол гэдгийг тооцоод дүрмийн санд оруулъя, хэдэн хувь байхыг тохироод эдийн засгийн онолоор зөв хиймээр байна. Компанийн засаглалын хувьд буруу зөрүү зүйлүүд байна. Бид юуны өмнө 2 хууль, стандартыг мөрдмөөр байна. Үүнд, ОУИТБС-ын ил тод байдлын тухай хуулийг санаачилан яригдаж байгаад одоо хаана очоод гацсан бүү мэд. Энэ хуулийг баталж чадвал ил тод байлгадаг, тайлагнадаг хоёр засаглалын том зарчмыг зохицуулж явах хууль. Нөгөө талаар Глобал Компакт гэж НҮБ-ээс гаргасан том стандарт байгаа. Энэ нь тэгш шударга байх, хариуцлагатай байх асуудлыг хязгаарлаж байдаг олон улсын том стандарт байгаа, үүнийг авч хэрэглэмээр байна. Одоо удахгүй уул уурхайн хууль гарах гэж байгаа юм байна. Түүнийг харахад дахиад л боломжгүй зүйлүүд орсон явж байна. Мэргэжлийн хүмүүсээ авч ажиллуулмаар байна, манайд чадвар мэдлэгтэй, докторууд олон байна. Ингэж гадаадынхантай мэдлэгээрээ уралдахгүй бол гарсан болгоныг нь сайн сайн гээд аваад байвал өөрийн ч юм байхгүй, хүний ч юм байхгүй болно. ОУИТБС-ын ажил 2005 оноос эхлэн өнөөг хүртэл нилээд сайн эмх, цэгцтэй явж байгаа. Энэ нь мэдлэгээ цуглуулах, хүчээ цуглуулах зөвлөлдөх, зөвшилцөх байдлаар ажиллаж байгаа нь том загвар болсон гэж бодож байна. Үүнд төр,

Үйлдвэрлэгч, иргэний ниймгийнхэн бүгдээрээ оролцож байгаа. Ийм ажиллагаатай өөр байгууллага бараг байхгүй, Үйлдвэрчний эвлэл гурвалсан гэрээ хийдэг байх. Иймээс энэ ОУИТБС-ын үр дүнг олон нийтэд маш зөв өгмөөр байна гэж судлаачийн хувьд үзэж байна. Одоо ОУИТБС-ын хууль, уул уурхайн хууль хүлээгдэж байна. Эдгээр хуулийг татварын орчинтой нь зөв зүйтэй уялдуулан гаргамаар байна. Монголд татварын хуулийг их олон солилоо. Орон нутагт төсөв, орлогын тодорхой хувийг өгмөөр байна. Энхсайханы Засгийн газрын үед ХАОАТ, ААНОАТ-ыг орон нутагт үлдээж байсан, орон нутаг бие дааж байсан. Өнөөдөр Эрдэнэт хот Эрдэнэт үйлдвэрээс хараат байна, цэвэр усаа авч, бохир усаа зайлуулж байна. Хэрвээ татварын 30 хувийг орон нутагт өгчихвөл хот нь хөгжиж, түүнтэй уялдан, нийгэм соёлын объектуудыг хотод нь өгмөөр байна. АМНАТ-ын аргачлал байна гэхдээ манайхан буруу юмыг жишиг болгоод байна. Авах ёстой юмаа авч болно, зөв ав, бид төлнө. АМНАТ-ыг гэрээний үнээр биш, Австралийн жишиг үнээр авах гэх мэт бүрүү юмнүүд байсан, үйлдвэрлэгчийг дампууруулдаг байдал их байсан Засгийн газар энэ дээр зоригтой алхам хийж, засаж залруулж ажиллаж байгаа. Тэр шийдвэрүүдийг үргэлжлүүлэх хэрэгтэй. За, ажлын төлөвлөгөөнд оруулах гэсэн саналаа бүгдийг нэг мөр хэлчихлээ.

Г.Соёлмаа: ОУИТБС-ын стандарт англи хэл дээр, баталгаажуулалт нь англи хэл дээр хийгдэж байгаа учраас англи хэл дээрх тайланг баримтлах нь зүйтэй гэж үзсэн. Зарим нэг нэршил, нэр томъёоны хувьд зөрүү үүсвэл англи тайланг баримтална гэсэн саналыг оруулсан. Мэдээж хэрэг орчуулгыг анхаарч ажиллаж байгаа. МХЕГ-ын арга хэмжээний талаарх мэдээлэл ирээгүй учраас тайланд оруулаагүй. Төслөөр тайлагнах гэдэг дээр бид эргэж хараад энэ зөвлөмжөө оруулахаар боллоо. Гэрээний ил тод байдлын тухай 133-р хуудсанд байгаа зөвлөмжийг анхаарч үзье.

Л.Баярмаа: За санал, асуултууд байна. Үүнд, 2016 онд Монросцветмет компанид хууль зөрчөөд олгосон байсан лицензийн мэдээллийг оруулсан байна. Энэ нь сайн хэрэг гэхдээ ойлгомжгүй байдлаар дүгнэсэн байна. Өөрөөр хэлбэл хууль зөрчиж олгосон гэдгийг оруулмаар байна. Мөн ийм материалууд бүрдүүлээгүй байсан байна гэж бичсэн байна. Хэрвээ материалууд бүрэн байсан бол хуулийн дагуу олгогдсон гэж үзэх үү? Ийм ойлгомжгүй юмнуудыг засмаар байна. Хууль зөрчөөд орон нутагт лиценз олгоод байгаа үйл явцыг дүгнэж, зөвлөмж өгмөөр байна. Заамар, Дэлгэрэх зэрэг сүмдэд хууль бус лиценз олгоод маш их зөрчил маргаан үүсгээд байна, үүнийг хууль дүрмийн хувьд олгох тухай дүгнэлт, зөвлөмж өгөхийг хүсч байна. Мөн лиценз олгох огнооны хувьд сонин дүгнэлт гарсан байна. Тухайлбал, 216 компанийн хэзээ лиценз авсан огноо нь тодорхойгүй байна гэсэн байна. Тэгэхээр энэ компаниуд Монгол улсын газар нутгийг хугацаагүйгээр ашиглаад, эзэмшээд явах юмуу, энэ чинь маш аюултай байдалд оруулж байна. Энэ чинь Үндэсний аюулгүй байдалд хүргэх нь байна. Алтан дорнод монгол, МАК компаниуд явж байна, хэзээ энэ компаниудын огноо ил болгох вэ? Энэ тал дээр Үндэсний зөвлөл ажилламаар байна. Цаашилбал, тайланд хуулийг дурдаад явсан байна, ус ашигласны төлбөрийг тухай хууль батлагдаад 5 жил болж байхад нэг ч компани төлбөр төлөөгүй байна гэсэн байна. Яагаад төлөөгүй гэдгийг нь бичмээр байна, яагаад гэвэл Байгал орчны яам журмаа гаргаагүй гэх мэт. Бид хичнээн мөнгө төлж байгаа, ийм ач холбогдолгүй дүгнэлт, зөвлөмж үнэлгээ хийвэл тайлан бараг

хэрэггүй болж байна, ийм олон хүмүүс цаг заваа гаргаад, хэлэлцээд саналаа өгөөд байдаг. Өнөөдөр Үндэсний зөвлөл батлах уу үгүй юу гэдэг асуудал яригдаж байна. Тайлангийн дүгнэлт, зөвлөмж, хэл найруулга алдааг нь сайн анхаарч боловсруулмаар байна. Хууль зөрчиж олгосон лицензүүдийг хуулийн дагуу олголоо гэж үзэж байна уу? үүнийгээ анхаараач ээ.

Н.Баярсайхан: Тайлангаа ирүүлээгүй төрийн байгууллага, компаниуд байна. Гаалийн ерөнхий газар, БОАЖЯ-ны яам мэдээллээ өгөөгүй гэж байна. Бид БОАЖЯ-ын өгөх мэдээллийн талаар ажлын хэсгийн хурал дээр ярьсан, яагаад өгч болохгүй байгаа юм бэ? Байгаль орчны нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн дансанд хэдэн компани барьцаа хөрөнгийг тусгай дансанд байршуулсан юм бэ? хэдийг нь буцаан өгсөн талаарх мэдээлэл авах гэж байгаа болохоос тухайн компанийн эсвэл яамны дансны хуулгыг авах гээгүй. Яагаад удаа дараа ийм асуудал яригдаад байна вэ? 2015 оны тайлангийн үеэр мэдээлэл авах гэж албан бичгээр хандахад сар гаран хүлээлгэсний эцэст энэ бол нууц гээд өгөөгүй, 2016 онд болохоор сүүлийн 2 жилд хөрөнгөө буцаан авсан компани байхгүй гэж хэлж байгаа. БОАЖЯ-ны Сайдын 2014 оны А-04 дүгээр тушаалаар батлагдсан журам гараад байгаль орчны барьцаа хөрөнгийг тайлагнах, ил тод нээлттэй болгох журам байгаа гэтэл мэдээллээ өгөхгүй байдаг. Мэдээллээ өгөхгүй байгаа яам, компанитай яаж ажиллах вэ, хуулийн ямар хариуцлага хүлээлгэх, Засгийн газар ямар арга хэмжээ авах вэ? Ерөнхий сайд маань ил тод байдлыг дэмжинэ гээд байхад яамдууд нь ийм байдалтай байхаар бидний ам ажил яаж нийлж ажиллах вэ? гэсэн асуудал байна. Ийм байхад яаж хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх вэ? Тэгэхээр өнөөдөр шийдвэрийн төсөл дээрээ дээрх асуудалд ямар арга хэмжээ авах талаар тусгах саналтай байна. Энэ удаагийн хурлаар тайланг батлахгүй байх санал гаргаж байна.

Б.Энх-Амгалан: Тэгэхээр гишүүдийн саналыг тусгаад дахин бөөнөөрөө хуралдана гэж үзэх үү?

Ж.Батцэнгэл: Сайн байцгаана уу, би Кэй Пи Эм Жи аудиттай хамтран ажилласан. Энэ компани 1,1 их наяд төгрөгийн анхны зөрүүг тулган баталгаажуулж, 74 сая төгрөгийн тайлбарлагдаагүй зөрүү болтол бүүрүүлсэн. Үндсэндээ хийх ёстой юмаа хийсэн гэж үзэж байна. Ажлын хэсгийн тайлан дээр хэлсэн саналуудыг тусган өнөөдөр танилцуулж байгаа тайлан илүү сайжирсан байна гэж зарим гишүүд хэлж байна, үүнийг дэмжиж байна. Мэдээллээ өгөөгүй байгууллагыг өгөөгүйгээр нь тусгасан байна. Энэ асуудал өмнө нь байсан байх, зөвхөн энэ жил биш. Хаагуур нь өнгөрсөн бэ гэдэг нь тусдаа асуудал байх. Энэ жил шилжүүлэг бүрээр нь тулган авч, нарийн нягт ажилласан гэж бодож байна. Иймд тайланг зарчмын хувьд батлах саналтай байна.

Б.Энх-Амгалан: За, хийсэн ажил их байгаа юм байна, татварын хүн маань гол юмаа мэдэж байгаа байх.

Н.Баярсайхан: Өнөөдрийн хуралдааны гол асуудал бол тайлан, төлөвлөгөөг батлахаар хязгаарлагдаж байна. Бид уул уурхайн салбарын засаглалыг сайжруулах, ил тод байдлыг бий болгох, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг асуудлаарх бодлогын асуудлаа ярьж амжихгүй байна. Иймд 2018 оны нэгдүгээр улиралд багтаан

үндэсний зөвлөлийн ээлжит хуралдааныг хуралдуулах саналтай байна. Батжаргал дарга, Мөнхбат нарын санал ч мөн бодлогын асуудал ярьж байна.

Б.Саран: Тайланг сайжруулах талаар үүрэг өгсөн, нилээд ажилласан байна. Цаашдаа шахаад шахаад энэ компаниас илүү юм гарахгүй юм байна. Иймд хууль эрхзүй, байгал орчны талаас нь мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллаж, тайлангаа сайжруулмаар байна. Ерөнхийдөө үндсэн суурь нь гарсан байгаа учраас хууль дүрмийн зөв үг хэллэгийг ашиглан, сайжруулах үүрэг өгөөд тайланг хүлээн авах саналтай байна.

Л.Түвдэндорж: КэйПиЭмЖи аудит Санхүүгийн аудит хийдэг Дэлхийн томоохон компаниудын нэг. Манай улсад албан ёсоор салбараа нээгээд ажиллаж байгаа ОУНББ-ын стандартыг мөрдөж ажилладаг 4 том компани байдаг. Эдний нэг нь КэйПиЭмЖи аудит юм. Иймээс санхүүгийн хувьд гаргасан тайланг хүлээн зөвшөөрч байна. Бүх асуудлыг эднийд нэгтгээд шаардлага тавиад байж болохгүй. Уул уурхайн аудит хийдэг, байгаль орчны аудит хийдэг тусдаа байгууллагууд байдаг. Цаашдаа энэ тайланг хийхэд үнэлгээний аудит хийдэг компаниудыг хамтарч хөлсөлж авах нь зүйтэй. Энэ компаниас холбогдолгүй асуудлыг шаардаад, тайланг хүлээж авахгүй байх нь учир дутагдалтай гэж бодож байна. Санхүүгийн асуудлыг нь хүлээж авах нь зүйтэй байх гэсэн санал байна.

А.Ариунзаяа: Хүмүүсийн саналыг сонсоод байхад дүгнэлттэй хэсэг нь учир дутагдалтай байгаад байна. Яагаад гэхээр цаашдаа тайланг ашиглаад бодлогын түвшинд ийм тайлан гарсан учраас үүнийг ингэж засах хэрэгтэй гэсэн баримттай байх ёстой гэдэг үүднээс тайлангийн дүгнэлт, зөвлөмж нь хэтэрхий бөөрөнхий, сул байна гэсэн шүүмжлэлийг сонслоо. КэйПиЭмЖи аудитын гарын хувьд улс төрийн маягийн дүгнэлт хийх үүрэгтэй юу? Харин аудит талаасаа хийсэн алдааг гаргаад ирсэн байгаа тайланд үндэслээд Үндэсний зөвлөл маань бодлогын дүгнэлт хийх үү гэсэн шийдвэр дээрээ анхаарч цаашдаа тайланг өнөөдөр батлах уу, үгүй юу гэдэг асуудал шийдэгдэх байх.

Г.Батцэнгэл: Статистикийн газрын саналыг дэмжиж байна. Тайлангаар 40 газрын лиценз хэзээ олгогдсон нь мэдэгдэхгүй байна гэдгийг аудитын компани гаргаад ирсэн. Үүнийг Засгийн газрын төлөөлөл, Ашигт малтмалын газар ажиллаад цаашдаа төрийн байгууллага, компаниудтай ажиллах нь бидний ажил гэж үзэж байна. Иймд аудитын хувьд хийсэн тайланг нь батлах нь зүйтэй гэж бодож байна.

А.Ариунзаяа: Ажлын хэсэг гаргаад ажиллаад, асуудал зөвлөмжөө тусгуулаад явбал зүгээр. Таван хүнтэй байхад болно.

Ж.Батжаргал: Тайлангийн ажлын даалгавар маань яг юу вэ? Бидний даалгавар тодорхой байж, түүнд тохирсон шаардлага тавьж, ажлаа хийлгэх хэрэгтэй. Тийм учраас тайланг нь зарчмын хувьд хүлээж авъя, бид нар ажиллаад зөвлөмж, дүгнэлтийг нь гаргая гэдэг асуудлыг хүлээн зөвшөөрөхгүй байна. Би хийлгэх ёстой ажлаа бүрэн хийлгэж авах ёстой. Дүгнэлт зөвлөмж нь тодорхой байж, цаашид авах ёстой арга хэмжээ нь төр засаг, бидний ажил байх.

Ю.Дэлгэрмаа: ОУИТБС-ын ил тод байдал гэдэг байгууллага нь шинэ байгууллага. Нэгтгэл тайлан хийсэн байгууллага маань санхүүгийн аудит хийдэг юм байна. Байгаль орчны хуулиуд хэрэгжихгүй байна гэж ярьсан. Тайлангийн зөвлөмжид байгаль орчин талаасаа анхаарч ажиллах санал байна.

Д.Эрдэнэчимэг: Энэ тайлан нь зөвхөн санхүүгийн тайлангийн аудит биш. Үндсэн мэдээлэлдээ асуудал байгаа учраас хүмүүс ингэж ярьж байна. Энэ ажлыг ямар хөрөнгөөр гүйцэтгэж байгаа билээ. Орчуулга дээр зөрүү гарч магадгүй гээд англи хувиа барина гэж ярьж сууж болохгүй. Нэг хүн төрсний төлөө асуултанд хариулж чадахгүй сууж байж болохгүй, энэ ажлын цаана бүхэл бүтэн баг ажиллаж байх ёстой байх. Зөвлөмж нь сул байгаагийн төлөө ажлын хэсэг гаргаад явж болох ч тэр хүмүүсийн мөнгийг хэн төлөх юм бэ? Нэгэнт мөнгө төлөөд ажиллуулж байж, дахин баг гаргаад ажиллаж болох уу?

Б.Энх-Амгалан: Энд байгаа гишүүдээс санал хураагаад тайланг зарчмын хувьд дэмжиг, гэхдээ ажлын хэсэг гарч ажиллаад тайланг хүлээж авах саналтай байна. Саналаа өгнө үү. Юмаа мэддэг, гишүүдээс оролцуулаад ажлын хэсгээ байгуулъя.

Ю.Дэлгэрмаа: Ажлын чадвар сул байна гээд өөр хүмүүс ажлыг нь хийх ёсгүй, болиулж болно.

Д.Эрдэнэчимэг: Аудитын компаниа дэмжээд тайланг сайжруулаад, сайжруулсан тайланг нь ажлын хэсэг хэлэлцээд бэлэн боллоо гэсэн тохиолдолд хурлаа хиймээр байна.

Б.Энх-Амгалан: Ажлын хэсэгт ажиллах сайн дураараа орох хэн байна? Харин цалингүй ажиллана.

Т.Баярхүү: Хараат бүс аудитын үтгэ алдагдах гээд байна. Бид ажлын хэсэг гаргаад зөвлөмж, дүгнэлт боловсруулах нь өөрсдийн санаа бодлоо аудитад тулгах гээд байна. Миний зүгээс, нэгэнт бэлэн болсон тайлангуудаа мэргэжлийн хүмүүсээс тусламж аваад ойлгомжтой болгомоор байна. Ажлын даалгаврын хүрээнд хийгдсэн ажил байгаа байх, бид ажлын хэсэг байгуулж ажиллах нь хараат бүс хөндлөнгийн ажилд нөлөөлөх болно.

Н.Баярсайхан: Иймд та бүхэн өөрсдийн хүмүүсээ сайн ажиллуулж, тайлангаа боловсронгуй болгох л хэрэгтэй, одоогийн танилцуулж байгаа хүмүүс урьд өмнө харагдаагүй, уулзаж байгаагүй хүмүүс тул ойлголцоход хялбар биш байх шиг байна. Иймээс Үндэсний зөвлөл дахин хуралдаж, хэлэлцэж, батлах нь хамгийн зөв санал юм.

Д.Галбаатар: Хамгийн өндөр дүн төлсөн гэж юуг хэлж байгаа юм бэ? Ийм их мөнгө зараад. Энэ танилцуулгыг батлаад Засгийн газрын архивт өгөх боломжгүй байна. Иймээс монгол үг хэллэг, орчуулгаа дахин сайн сайжруулах хэрэгтэй.

Ш.Цолмон: Тайланг ажлын хэсэг хуралдсанаас хойш нилээд ажилласан. Жишээлбэл, МХЕГ-аас 10 гаруй компанид торгуулийн арга хэмжээ авсан гэсэн мэдээлэл ирсэн, түүнийг КэйПиЭмЖи аудитад хүргүүлсэн гэх мэтээр хамтран ажилласан. Тайланг ОУНБДнГ-т хүргүүлсэн, өмнөх тайлангаа бодвол нилээд сайжирсан байна гэдэг хариу ирсэн, эцсийн дүгнэлт арай ирээгүй байна. Дүгнэлт, зөвлөмжийн дагуу ажиллах нь бидний ажил байгаа. Тус компанитай 2017 оны 4 сард гэрээ байгуулан, энэ тайлан дээр нилээд олон сар ажилласан. Томоохон компаниудаас өрсөлдөж, гарч ирсэн. Бидний хувьд сэтгэл хангалуун байгаа, авах ёстой мэдээлэл авсан гэж үзэж байна. Иймд тайлангаа батлаад, цаашид сайжруулсан тайлангаа танилцуулж, хүлээн авах нь зүйтэй байх гэсэн саналтай байна. 2017 оны тайлангийн үнэлгээний хороо он гараад 1 сарын 10-ны дотор байгуулах ёстой гэх мэтээр төлөвлөгөөт ажлууд ар араасаа байгаа. Тайланг хойшлуулах нь дараа дараагийн ажилд нөлөөлөөд, чанартай чанаргүй ажлууд гарах асуудал бий болох тул боломжтой саадгүй явуулах үүднээс зарчмын хувьд батлаад, гишүүдийн саналын дагуу сайжруулаад тайлангаа ирүүлээсэй гэсэн саналтай байна.

Б.Энх-Амгалан: За одоо үндсэн гишүүдээс санал хураая. Тайланг зарчмын хувьд дэмжиж байгаа нь гараа өргөнө үү. 22 гишүүнээс 14 гишүүн дэмжиж байгаа тул зарчмын хувьд тайланг дэмжиж байна. Цаашид тайланг сайжруулах үүрэг болгож байна.

А.Ариунзаяа: Аудитын байгууллагын хувьд тайлангийн зөвлөмж, орчуулганы найруулгаа дахин сайн хянаад, сайжруулах шаардлагатай юм байна. Бид үүнийг оруул, тэрийг боль гэж шаардах боломжгүй юм байна. Зөвлөмж, дүгнэлт дээрээ хууль эрхзүйн үндэслэлийг нь сайн оруулаад, монгол хэлээр ойлгомжтой байхаар засах хэрэгтэй.

С.Энхтуяа: Тайлан нь монгол хэл дээр зөв найруулгатай байх нь хамгийн хэрэгтэй. Яагаад гэвэл энэ тайлан батлагдаад олон нийтэд нээлттэй тавигддаг. Хэрвээ ийм тайлан тавигдвал бидэнд төдийгүй та нарт ч онцгүй байх болно.

Б.Энх-Амгалан: Өнөөдөр тайлангаа зарчмын хувьд батлаад, 2018 оны 1 сарын 15-ны дотор сайжруулсан тайлангаа Ажлын албанд хүлээлгэн өгөхөөр тохирох үү?

Ж.Батжаргал: Хараат бус гэдгийг буруу ойлгоод байна. Энэ тайланг урьдчилсан байдлаар сонсоод дүгнэлт, зөвлөмжид чиглэлээ өгөхийг хараат бус байдалд нөлөөлөх гэж үзэхгүй. Харин аль нэг оролцогч талууд өөрсдийн санаа бодлоо тулгаад тайланд оруулах гэвэл тэр нь хараат бус байдалд нөлөөлчихвий гэж ярьсан.

Б.Энх-Амгалан: 2016 оны нэгтгэл тайланг батлалаа. Шийдвэрийн төслийг уншиж танилцуулъя.

Н.Баярсайхан: Бид тайлангаа УИХ-ын Төсвийн байнгын хороонд танилцуулах ажлыг жил бүр яриад, хийж чаддаггүй, иймээс хуралдааны шийдвэрт ОУИТБС-ын тайланг УИХ-ын холбогдох байнгын хороодод танилцуулах гэж оруулах саналтай

байна. Мөн мэдээллээ өгөхгүй байгаа байгууллага, компаниудад ямар арга хэмжээ авах талаар шийдвэрт оруулмаар байна.

Д.Эрдэнэчимэг: Бид шийтгэхдээ гол биш, бидний энд яриад байгаа зүйл тухайн байгууллага дээр очиж яригдаж, ажил болохгүй байна. БОАЖЯ-наас нэг хүн байнга ирдэг, гэтэл энд ярьсан асуудлыг яамандаа танилцуулахгүй байгаа учраас жил бүр ужиг болон яригдаад байгаа. Тэгэхээр тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байна.

Б.Энх-Амгалан: Тайланг байнгын хороонд танилцуулъя. Бид торгодог, арга хэмжээ авдаг байгууллага биш.

Н.Баярсайхан: Ерөнхий сайд, Засгийн газрын зүгээс уул уурхайг дэмжинэ, гэхдээ байгаль орчинд ээлтэй байх ёстой гэж ярьж байгаа. Иймээс ЗГХЭГ-ын дарга БОАЖЯ-тай байгуулж байгаа үр дүнгийн гэрээнд энэ талаар үүрэг тусгаж оруулах ямар боломж байна. БОАЖЯам 2 жил дараалан мэдээллээ өгөхгүй байна. Бид ямар ч хариуцлага тооцож чадахгүй байна.

Г.Уранцоож: Ерөнхий сайд Үндэсний зөвлөлийн дарга, Уул уурхайн сайд орлогч дарга нь юм чинь тайлангаа Засгийн газрын хуралдаанд оруулж болох үү?

Б.Энх-Амгалан: Болно оо, энэ талын үүргийг бид хүлээе гэхдээ олон хүн орох боломжгүй байдаг

Н.Баярсайхан: Яах вэ, талуудын төлөөлөл ганц хоёр нь оролцоё.

Б.Энх-Амгалан: За баярлалаа, аудитын байгууллагын төлбөрийг энэ ондоо өгөхгүй бол төсвийн хуулиараа хураагддаг юм байна.

Н.Баярсайхан: Мөнгийг нь ондоо багтааж өгөх шаардлага байгааг ойлгож байна, өгөх гэдэг дээр дэмжиж байна. Харин КэйПиЭмЖи сайн компани байлаа гээд энэ төсөл дээр хангалтгүй ажиллаж байгаагаа дүгнэж, энэ тайлан дээр сайн ажиллаж хүлээлгэн өгөх хэрэгтэй. Дараа жил бол итгэл хүлээлгэх хэмжээнд ажиллахгүй юм байна.

Б.Энх-Амгалан: За дараагийн асуудалдаа оръё, танилцуулгыг ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулна.

2. ХЭЛЭЛЦСЭН НЬ: Монгол Улсын ОУИТБС-ын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, 2018 оны төлөвлөгөөний төслийн тухай

Ш.Цолмон: За баярлалаа, 2017 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2018 оны төлөвлөгөөний төслийг нэгтгэн товчхон танилцуулна. 2017 онд нийт 75 үйл ажиллагааг ажил хийхээр төлөвлөснөөс одоогийн байдлаар 54 үйл ажиллагааг хэрэгжүүлж, биелэлтийн хувь 74 байгаа. Ажлын хэсэг 3 удаа, дэд хэсэг 2 удаа хуралдсан. Хийгдсэн томоохон ажлуудыг дурдвал, 2016 оны ОУИТБС-ын тайлан гаргах аудиторын түншлэлийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж

КэйПиЭмЖи аудит шалгаран 2017 оны 4 сард гэрээ байгуулж, 6 дугаар сард эхлэлийн тайлан, 11 дүгээр сард төслөө танилцуулсан. Одоо эцсийн тайланг танилцуулж байна. 2016 оны тайланг ОУИТБС-ын стандартын дагуу бэлтгэн боловсруулж, 213 компанийн тайланг Засгийн газрын тайлантай тулган баталгаажуулж, өнөөдөр дүнг танилцуулж байна.

Компани, Засгийн газрын байгууллагуудын 2016 оны тайлагнах ажлыг зохион байгуулж, 1227 компани, төрийн 7 агентлаг, 9 дүүрэг, 15 аймаг ОУИТБС-ын тайлан гаргасан байна. Сангийн яамны гаргаснаар олборлох салбарын орлого 1,2 их наяд төгрөгөөр гарган.

Засгийн газрын 2012 оны 222-р тогтоолыг шинэчлэн 9 дүгээр сард өөрчлөлт оруулсан. Уг шинэчлэлээр ОУИТБС-ын олон улсын стандарт, түүний шаардлага, дүрэм, протоколыг бүрэн хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэх, Ашиг хүртэгч эздийг ил тод болгох тухай хуулийг төслийг 2017 онд багтаан Засгийн газарт багтаан барих. 2019 оноос эхлэн орон нутгийн дэд зөвлөлийн санхүүжилтийг улсын төсвөөс гаргах зэрэг чухал шийдвэрүүдийг гаргасан.

ОУИТБС-ын ОУНБДнГ-тай хамтран Ажлын хэсэг ашиг хүртэгч эздийг ил тод болгох дэд хэсгийн уулзалт, сургалтыг 9 дүгээр сард зохион байгуулсан. “Замын зураг 2020 он” төлөвлөгөөний хүрээнд 9 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох тодорхойлолтуудыг боловсруулсан. УУХҮ-ийн яам Ашиг хүртэгч эздийг ил тод болгох тухай” хуулийн ажлын дэд хэсэг байгуулан ажиллаж байна.

Эрдэнэс Монгол компани, КэйПиЭмЖи компанитай хамтран төрийн өмчийн компаниудад 2016 оны тайлан гаргах арга зүйн сургалтыг зохион байгуулж, 100 гаруй уул уурхайн компаниудын төлөөлөл оролцсон.

Орон нутгийн харилцааны ажлын сайжруулах зорилгоор Сэлэнгэ Ерөө, Төв аймгийн Заамар, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Өмнөговь аймгийн Гурван тэс, Дорноговь аймгийн Дэлгэрэх сумдад ЕСБХБ-ны санхүүжилтээр жишиг сум байгуулах туршилтын төсөл амжилттай хэрэгжиж, явцын дүнг ажлын хэсэгт танилцуулан чиглэл авч байна. 2018 оны 1 дүгээр сард энэ төслийн үр дүнг танилцуулахаар бэлтгэж байна.

Гэрээний ил тод байдлын цахим санг ашиглалтад оруулж, хамтран ажиллах санамж бичгийг УУХҮЯ, Нээлттэй нийгэм форумтай байгуулсан, энэ санд 35 гэрээний эх хувийг байршуулж, холбогдох тайлбар танилцуулгыг Орон нутгийн иргэдэд мэдээлэл өгөх, зөв ойлголттой болох, Эрдэс баялагийн салбарт төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын 222-р тогтоолыг хэрэгжүүлэхэд энэ ажил чухал учраас хөдөө орон нутагт чиглэн ажиллаж байна. Үндэсний хөгжлийн газартай хамтран орон нутгийн төлөвлөлтийн семинар зохион байгуулсан.

Гэрээний ил тод байдлын хүрээнд цахим санг байгуулсан. Үүнд Нээлттэй нийгэм форум дэмжлэг үзүүлэн ажилласан. УУХҮЯам, Нээлттэй нийгэм форум манай ажлын алба хамтран ажиллах санамж бичиг байгуулсан, энэ санд 35 гэрээний эх хувийг байршуулсан. Нээлттэй Засгийн түншлэлд Ашиг хүртэгч эздийг ил тод болгох асуудлыг танилцуулж, Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгуулсан байна. Үндэсний хөгжлийн газартай хамтран орон нутгийн төлөвлөлтийн сургалт, Хэвлэлийн хүрээлэнтэй хамтран сэтгүүлчдийн сургалт, Монголиан майнинг сэтгүүлийн газартай хамтран 21 аймгийн сэтгүүлчдийн чадавхийг бэхжүүлэх сургалтыг тус тус амжилттай зохион байгуулсан байна.

Монголын ОУИТБС-ын ахиц дэвшлийн тайланг боловсруулан танилцуулж байна. ОУИТБС-ын тайланг Үндэсний зөвлөлийн хурлаар батлах ёстой. Тайланг ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч орнуудын гаргах загварын дагуу хийсэн. Урьдчилан та бүхэнд хүргүүлсэн байгаа.

2018 онд хэрэгжүүлэх ажлын хүрээнд дөрвөн зорилтыг тавьсан. Үүнд, ОУИТБС-ын Олон улсын баталгаажуулалтаар өгсөн зөвлөмж, Монгол улсын 2016 оны нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх, ОУИТБС-ын 2017 оны тайланг боловсруулах, батлах олон нийтэд мэдээлэх, Үндэсний болон орон нутгийн түвшинд ОУИТБС-ыг хэрэгжүүлсний нөлөө, ач холбогдлыг оролцогч талуудад суртчилах, хамтын ажиллагааг сайжруулах, Ашиг хүртэгч жинхэнэ эздийн ил тод байдлыг хангахад чиглэсэн эрхзүйн орчинг бүрдүүлэх, мэдээлэл бүртгэлийн тогтолцоог сайжруулах гэсэн 4 зорилго, 10 зорилт, 37 үйл ажиллагааг бүхийн 2018 оны ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулж, холбогдох ажил, гарах үр дүн, хариуцах тал, хугацаа, зардлын хэмжээ, эх үүсвэрийн хамт танилцуулж байна. Төлөвлөгөөний биелэлт болон 2018 оын төлөвлөгөөг ажлын хэсгийн хуралд танилцуулж, санал авсан байгаа. Үндэсний зөвлөлийн гишүүд та бүхнийг төлөвлөгөөг баталж, саналаа өгөхийг хүсье.

Б.Энх-Амгалан: Бид Олон улсын санаачилгад нэгдэж орсон тул, ОУ-ын үүргээр хүлээсэн тайлангаа гаргаж байна. Санхүүжүүлэгчийн шаардсан стандартын дагуу ажиллах хэрэгтэй. Иймд дорвитой, чанартай ажлуудыг хийх хэрэгтэй байна. Сургалт, суртчилгааны ажилд иргэний хөдөлгөөнийхөнийг дэмжиж, түлхүү оруулмаар байна. Дараагийн асуудал бол гар аргаар, хууль бусаар ашигт малтмал олборлогчидтой тэмцэх ажил хиймээр байна. Энэ хүмүүст төрийн хяналт, хууль дүрэм хүрч чадахгүй байна. Жижиг учраас бултаад алга болчихдог, төрийн хуулиар арга хэмжээ авах гэхээр олддоггүй. Ийм асуудлуудыг яах вэ? Та бүхнийг танилцуулгатай холбогдуулан саналаа хэлэхийг хүсэж байна.

Н.Наранцэцэг: 2017 оны төлөвлөгөөн дээр зарим нэг ажлууд хийгдээгүй орхигдсон. Тухайлбал, гэрээг ил болгоно гэсэн байсан одоогийн байдлаар 200 компаниас 30 гэрээ ил тод болсон байна гэж байна. Үлдсэн компанийн гэрээ хэзээ ил болох вэ? 2018 онд энэ ажил үргэлжлэн хийгдэх үү?

Ш.Цолмон: 2017 онд хийгдээгүй ажлууд бүгд 2018 онд хийгдэхээр байгаа.

Н.Баярсайхан: Төлөвлөгөөний биелэлтийн 3,3 дээрх ажил хийгдсэн гэсэн үгүү? 300.0 гэдэг нь ямар учиртай вэ?

Ш.Цолмон: Уул уурхайн яамнаас мэдээлэл ирсэн учраас хийгдсэн гэж үзсэн. Ажлын хэсэг гарч ажилласан.

Б.Дэлгэрмаа: Төлөвлөгөөний урд талын багана дээр төсөвлөсөн дүн, хойд талд нь биелэлт, мөнгө гарсан бол дүнг нь тавьсан байгаа. Энэ ажилд 300 000 төгрөг төсөвлөөд, зардал гараагүй хийгдсэн байна.

Б.Баярмаа: Ажлын төлөвлөгөөний биелэлтийг харахад бид хийх ажилгүй, бараг 100 хувийн биелэлттэй байна. Зорилгыг нь харахаар маш том зорилго байна. ТӨК-үүдын ил тод байдлыг бүрэн хангах, биелсэн гэсэн байна. Харин биелэгдсэн байдлыг уншихаар хэдэн сургалт зохион байгуулсан байна. Сургалт зохион

байгуулснаар ТӨК-ууд ил тод байдал нь бүрэн хангагдах юм уу? Үүнийг бодитой болгомоор байна.

Б.Энх-Амгалан: Босгоо намсгаад, биелэлтээ бодитой болгомоор байна.

Ш.Цолмон: ОУИТСБ-ын стандартын шаардлагын хүрээнд биелэлтийг оруулсан.

Б.Баярмаа: Ойлгосон, тэгэхээр төлөвлөлтөө бодитой болгомоор байна. 2018 оны төлөвлөгөө яг энэ байдлаар хийгдсэн байна. Хэдэн сургалт хийгээд ил тод байдал хангагдана гэж байхгүй. Лицензийн огноог ил тод болгох гэж 2017 онд төлөвлөсөн байна. Гэтэл тайлангаар 40 гаруй компанийн лицензийн огноо ил болоогүй байна гэж байна. Ингээд бодит байдал дээр зөрчилдөөд байна. Тэгэхээр 2018 оны төлөвлөгөөгөө ингэж хийж, бие биенийгээ хуурч явмааргүй байна. Бид хийж чадах, бодитой, хийгдэх боломжтой ажлуудаа төлөвлөгөөнд оруулмаар байна. Зөвлөх ч тэгэж хэллээ. Ер нь тайлангийн зөвлөмж, дүгнэлттэй холбоотойгоор ажлаа төлөвлөмөөр байна. Төлөвлөгөөгөө бодитой, хэмжигдэхээр хиймээр байна. Бид маш их сургалт хийсэн, брошур тараасан үр дүнгүй зардал гарч, хайран мөнгө үрэн таран болоод байна. Бид сургалт хийгээд, брошур тараагаад асуудал шийдэгдэхгүй байна. Төлөвлөлтөө бодитой, үр ашигтай дараа нь хэмжиж болохоор, үнэлж болохоор хиймээр байна.

Б.Энх-Амгалан: Таны үг маш их таалагдлаа. Том үриа лоозон шиг том том зорилт тавьчихаад ийм юм хиймээргүй байна. Өмнө хийсэн юмнуудаа үгүйсгээд яах вэ. Одоо босгоо намсгаад, хүн нийгэмд хэрэгтэй чадах юмнуудаа төлөвлөө. Ямар нэгэн үр дүн гарахаар энгийн үг хэллэгтэй байлгаж болох уу? заавал ийм байх ёстой юу? Иймээс 2018 оны төлөвлөгөөн дээрээ өнөөдөр сайн сууж ажиллая.

Д.Эрдэнэчимэг: Энэ төлөвлөгөө ганцхан ажлын албаны хийсэн төлөвлөгөө биш, бид өнгөрсөн жил бүгдээрээ тойрч сууж байгаад, ярилцаад батласан. Төлөвлөгөөний босго намсгана гэдэгтэй санал нийлэхгүй байна. Энэ сурталчилгааны ажлыг сургалт хийхгүйгээр яаж хийх вэ? Гэрээний ил тод байдал гэдэг дээр сургалт, мониторинг зэргийг манай Нээлттэй нийгэм форум хамтарч ажилласан шүү, үүнийг дурдаад өгөөрэй.

Б.Батжаргал: Бид ОУИТСБ ийн талаар ярихдаа зөв талаас нь хармаар юм шиг байна. Юуны өмнө тусгай зөвшөөрлүүдийн олголтын үйл явцад ерөнхий анхаарал хандуулмаар байна. 2015, 2016 онуудад хайгуулын лиценз олголт замбараагүй олгосон. Тэр байтугай Баянхонгор аймагт газар чөлөөлүүлээд оронд 3000 га газар олгосон зэрэг асуудал гараад байгаа. Мөн БОАЖЯ байгаль орчныг нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн төлбөрийг компаниудад буцаан олгохгүй байсаар нөгөө компаниуд нь хөрөнгөө байршуулсан гээд хаяад алга болсон. Одоо тэгэхээр нь нөхөн сэргээлт хийлгэхийн тулд үүсмэл орд болон нөхөн сэргээлт хийсэн талбайг хөндөөд цаашлаад эрүүл газрыг ухаад байдаг болсон. Иймд нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг бүгдийг гаргаж ирээд, эзэн холбогдогч нь байхгүй талбайг уг хөрөнгөөр хийлгээд, эзэн хариуцагч нь байгаа талбайг хөрөнгөөр нь бярааж хийлгэмээр байна. Ингэж чадвал бидний ажлын нэг том хэсэг болох юм. Төсөвт төлсөн мөнгө гаднын

компаниар аудит хийлгэсэн хийлгээгүй тодорхой гараад ирнэ, төсөвт төлсөн л бол. Нөгөө талаар орон нутагт нийгмийн хариуцлагын тухай гэрээ хийгээд компаниудаас хөрөнгө аваад орон нутгийн хөгжил, бүтээн байгуулалт руу чиглүүлж байгаа, тэр бол нарийндаа ил тод болох ёстой зүйл. Энэ нь мэдээлжихгүй байгаа, бүртгэлийг нарийн болгож, мэдээллийн санд оруулаад, дараа нь үр дүн зарцуулалтыг тайлагнадаг болгосоор байна. Энэ жил Төв аймгийн гэрээг нэгтгүүлэх ажил хийсэн, гэрээн дээрээ компаниуд 580 сая төгрөг өгнө гэсэн боловч 401 сая төгрөг авсан гэж гарсан. Өөрөөр хэлбэл 180 орчим сая төгрөгийн зөрүү гараад байгаа, баримт байхгүй. Дараагийн асуудал бол жишиг таван суманд төсөл хэрэгжүүлж байна гэж байна. Тэрийг жинхэнэ утгаар нь ажиллуулаад бусад үүл үүрхайтай сумдад нутагшуулах хэлбэрээр явбал илүү үр дүнтэй.

Г.Уранцоож: Төлөвлөгөөг харахаар лицензүүдийг ил тод болгох талаарх ажлууд нь өнгөрсөн жил хийгдэж байсан юм байна, дараа жил дахин хийгдэж байгаа юм шиг харагдаж байна. Хэрвээ ноднин жил ил тод байдлыг хангах ажил хийгдсэн бол энэ жил хариуцсан албан тушаалтны ажил үүргийн хуваарьт оруулаад, тогтмол хийдэг болговол зүгээр юмуу, магадгүй шинээр олгосон зөвшөөрөлтэй холбоотой байж болох байх. Үүнийг хариуцсан ажилтан хийгээд, улсын төсвөөс цалингаа аваад ажлаа хийгээд явдаг болох ёстой юм шиг санагдаж байна, заавал санаачилгын ажлын алба хариуцаад, гаднын хөрөнгөөр хийгдэж байх ёстой юм уу гэсэн асуулт байна. Хоёрдугаарт, Ашиг хүртэгч эздийг ил тод болгох тухай 2020 он хүртэл хийх замын зураг, төлөвлөгөөнд лиценз эзэмшигчийг ил болгоно гэсэн байгаа. Лиценз эзэмших чинь өөрөө гэмт хэрэг юм уу, яагаад зугтаагаад байдаг юм бол эсвэл татвараас зугтаагаад байгаа юм уу, хэрвээ тийм бол тэр чинь гэмт хэрэг болох байх заавал үүнийг ил болгох гээд хөөцөлдөөд байх шаардлага байгаа ч юм үү үгүй ч юмуу? Нөгөө талаар компанийн захирал, хуулийн зөвлөхтэй нь ажиллана гэсэн байна, тэр нь үр дүнтэй байх уу, нэгэнт тэд гэрээ хийгээд нууцыг нь хадгална гээд ажиллаж байгаа. Нэгэнт газар улсын өмч гэдэг юм чинь хэрвээ ил болгохгүй бол цуцлаад, улсын өмч болгож болдоггүй юм уу? Үүний төлөө ингэж ажиллах шаардлага байна уу? 2020 он хүртэл ажиллахаар төлөвлөж, 60-70 мянган евро зарцуулахаар тавьсан байна. Энэ нь надад тиймхэн санагдсан.

Н.Баярсайхан: Ажлын төлөвлөгөөнд хагас жилд нэг удаа зургадугаар сард ч юм уу Үндэсний зөвлөлийн хурал хийхээр нэмж оруулах саналтай байна. Үүгээр бодлогын шинжтэй асуудлуудаа ярьмаар байна. Мөн бичил уурхайчдын талаарх асуудлыг яах вэ, түмпэнгээ бариад амьдралын эрхээр ухаад явж байгаа хүн ч байна, хэсэг бүлэг болж нэгдээд нөхөрлөл байгуулаад, ажил олгогчийн хүрээнд ажиллаж байгаа хэсэг ч байгаа. Бүр дайрч ороод шөнө нь олборлоод явчихдаг, техникужсэн хүмүүс ч байна. Энэ талаар судалгаа хийгээд, бодлого боловсруулаад, Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцэх саналтай байна. Бичил уурхайчид буюу нинжа нар хаа сайгүй байна, Төв аймгийн Заамар, Баянхонгор аймагт Сэлэнгэ аймагт ч байна. Эднийг яах вэ?

Ажлын хэсэг гарч ажиллая гэсэн санал байна. Сая Төв аймгийн засаг дарга ярилаа, ер нь Засгийн газрын 179 дүгээр тогтоолд стратегийн ордод аймгийн Засаг дарга гэрээ байгуулна, стратегийн бүс ордод сумын засаг дарга гэрээ байгуулна гэж заасан байдаг. Тэгэхээр 15 стратегийн ордод аймгууд гэрээ байгуулсан байгаа, энэ гэрээ байгуулсан үе шатанд ИНБ мониторинг хийе.

Бид сая 2016 оны тайланг баталсан, тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулаад, ажлын төлөвлөгөөнд тусгаж ажиллая.

Мөн бидний хийж чадахгүй байгаа нэг зүйл бол Ил тод байдлын тухай хуулийг батлуулах ажил орхигдоод байгаа, хуулийн төслийг яах вэ, эрхзүйн орчноо яаж баталгаажуулах вэ гэдгээ авч үзье. Энэ талаар ажлын хэсэг гарч ажиллаад, хагас жилээр хийх Үндэсний зөвлөлийн хурлаар илүү шийдлүүдийг гаргаад явъя гэсэн ажлуудыг оруулъя.

Иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангая гэсэн саналыг дэмжиж байна, бид хамтарч ажиллана. Сургалтыг жилийн ажлын төлөвлөгөөндөө тусгаад бид хийх шаардлага байгаа, хийх хэрэгтэй, харин хэнд хийх вэ гэдгээ бодох хэрэгтэй, яг тайлан гаргадаг компанийн санхүү, санхүү төрийн сангийн ажилтан гэх мэт шаардлагатай хүмүүст сургалт хийж, фокуслах хэрэгтэй. Төрийн байгууллагын дарга албан тушаалтнууд болон компанийн тайлан гаргадаг санхүүгийн хүмүүс байнга солигддог учраас сургалт хийх зайлшгүй шаардлага байгаа, сургалтаас залхах хэрэггүй, хийгээд байх хэрэгтэй.

Б.Энх-Амгалан: Төлөвлөгөөгөө батлах уу?

Ю.Дэлгэрмаа: Сургалт сурталчилгааны ажил өмнө нь хийгдэж байсан, цаашдаа ч хийгдэж ёстой, гэхдээ сургалтаас гадна ард түмнийг мэдээллээр хангах, энэ төслийн үйл ажиллагааг сурталчилах зорилгоор телевизийн нэвтрүүлгийг түлхүү хийвэл айл бүрт илүү хүрэх байх үүнийг анхааралдаа авна уу? Лицензийн олгох явцыг ил тод болгох хэрэгтэй байна. Шинэ Засгийн газар лиценз олголтыг зогсоолоо гэсэн. Өмнө нь олгосон лицензүүдийг яах вэ, байлгаад байх уу? Энэ тал дээр анхаарч, холбогдох газруудтай хамтран ажиллах хэрэгтэй байна, бид шинэ Засгийн газрыг их юм хийх байх гэж харж байгаа. Байгаль орчны тухай хуулиуд хэрэгждэггүй, бид шинэ Засгийн газрыг их юм хийх байх гэж харж байгаа. БОАЖЯам өөрөө мэдээллээ гаргаж өгдөггүй, тэнд хариуцлага тооцуулъя. Биелэхгүй том том юм ярьж байхаар жижиг юм шиг олон асуудлыг шийдвэл хэрэгтэй байна. Ер нь хууль хэрэгжүүлэх чиг үүрэгтэй яамдууд нь ажлаа хийчихвэл, бид нар заавал нинжа нартай хэрэлдээд, сайн муугаараа дуудуулаад байх шаардлагагүй. Тэгэхээр хуулийн хэрэгжилт хангалтгүй байна, шинэ Засгийн газраас итгэл найдвар хүлээсэн нүдээр горьдож харж байна. Ард түмэн хууль хэрэгжээд, шударга байвал бусад асуудал болно гэж бодож хүлээж байна. Манай зөвлөлд Ерөнхий сайд байдаг, ахлах зөвлөхөөр дамжуулан хүргэмээр байна. Ерөнхийдөө төлөвлөгөөг дэмжиж байна, өөрийн саналаа нэмж хэллээ.

Д.Цэрэнжав: Байгаль орчны хэрэгжилт гээд бүтэн бүлэг асуудал орох болох байна. Бид саналаа нэмээд байвал нэмээд л байна. Тийм учраас зарчмын асуудлаа шийдсэн нь зөв, асуудлаас халиад явчихлаа.

Б.Болдбаатар: Одоо ажлын алба нь цахим орчноо сайн идэвхжүүлэх хэрэгтэй байна. Хөдөө орон нутгууд ихэнх нь интернэттэй, 4 G орчихсон байгаа. Фэйсбүүкээ сайн ажилллуулаад мэдээллээ сайн өгвөл түүгээр сургалт ч хийх боломжтой, зардал ч хэмнэнэ гэж бодож байна.

Б.Дэлгэрмаа: Төсөл хэрэгжүүлж буй сумдад фэйсбүүк орчныг идэвхтэй ажиллуулж байгаа, сумын мэдээллийн сонинг гаргаж, мал тооллогоор малчдад тараасан гэх мэтээр зорилтот бүлэг рүү чиглэсэн учраас Улаанбаатарт байгаа бид нарт ажиглагдахгүй байж магадгүй. Бид энэ төслийн үр дүнг үнэлээд, дараа оны нэгдүгээр сард танилцуулна.

Д.Галбаатар: Өнөөдөр ОУИТБС-аар олон мэдээлэл ил тод болж байгаа. Бүх мэдээллээ цахим хуудсандаа тавьж байгаа. Хоёр асуудал байна. Нэгдүгээрт, хуулиудын давхацлыг арилгаж нэг ойлголттой болох асуудал юм. Төрийг муу менежер гэдэг гэхдээ энэ нь төрөөс бус төрд ажиллаж байгаа хүмүүсээс шалтгаалдаг. Төрийн хууль хэцүү, хямралтай холбогдуулаад төрийн байгууллагууд хувь хүн, гаднын байгууллагад хандив өргөж болохгүй гэсэн Засгийн газрын тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэр байгаа. Баяр наадам тэмдэглэж болохгүй гэсэн тогтоол байдаг. Энэ утгаар нь авч үзвэл төрийн өмчтэй үйлдвэрүүдийн нийгмийн хариуцлагыг хягаарласан юм шиг, нөгөө талаас Эрдэнэт үйлдвэр хажуудаа олон нийгмийн цех байгуулаад өөрийн ашгаас санхүүжүүлээд явж байгааг тайланд оруулдаггүй г.м. зөрчилтэй зүйлүүд олон байна. Миний хэлэх гээд байгаа санаа бол ОУИТБС-ын стандартыг Монгол улсын хууль тогтоомжтой нийцүүлэн баталж мөрдөх явдал юм. Аливаа юманд авах гээхийн ухаанаар хандмаар байна. Сонирхолын асуудлаас болоод орон нутаг үйлдвэрлэгчдийн харьцаа тасрах нь байна. Орон нутгийнхан манай газрыг авлаа, малын бэлчээрийг сүйтгэлээ гэх мэт. Тийм учраас Ашигт малтмалын тухай хуулинд байгаа Орон нутагтай ажиллах хамтын ажиллагааны гэрээг загвар болгомоор байна. Түүнд цөөн хэдэн асуудал тусгагдсан байдаг. Ажлын байр, дэд бүтэц, байгал экологи зэрэг асуудал тусгагдсан байдаг, ийм баймааргүй байна. Манай яамны сайд дэд дарга байдгийн хувьд үлгэр жишээ гэрээний загвар боловсруулмаар байна. Хуучин Ашигт малтмалын тухай хуулинд хувь байсан хувь хэмжээг сэргээмээр байна. Уул уурхайн хуулиндаа нөхөн сэргээлтийн тухай оруулмаар байна, үүнийг судалгаатай шинжилгээтэй ажиллаад хуулийн зохицуулалт хийгээд бодлогын асуудлаа тодорхойлмоор байна. Хууль эрхзүй, уул уурхай болон засаглалын талаарх мэдлэг, туршлагатай хүмүүсээ авч ажиллуулаад хууль эрхзүйн орчинд тохирсон бодлого гаргамаар байна. Хэрвээ бодлого зөв болвол бүх зүйл эмх цэгцтэй болно. Бид нэгэнт ОУИТБ-ын замаар явахаар сонгосон байгаа, иймээс ил тод байдлын тухай хуультай болмоор байна. Ер нь явах замаа эхлээд тодорхойлж байж амжилт гарна аа. Өнөөдрийн ярьсан зүйл бол ажлын төлөвлөгөө гэдгээс илүүтэйгээр бодлогын асуудал байлаа.

Б.Тэрбиш: Сургалт хийх ажлыг дэмжиж байна, гэхдээ ямар сургалтыг ямар зорилтот бүлгүүдэд хийх вэ гэдэг дээр санал хэлье. АТГ 2017 оны намар сонгуулийн дараа шинээр томилогдсон орон нутгийн удирдлагуудад сургалт хийсэн. Эдгээр хүмүүст сургалт хиймээр байна. Сумдыг сонгохдоо уул уурхайн үйлдвэрлэл явуулдаг, удирдлага нь солигдсон цөөн тооны сумдыг сонгож аваад, мэдээлэл хүргүүлэх боломжтой, үүнд АТГ-ын Соён гэгээрүүлэх хэлтэс хамтарч ажиллахад бэлэн байна. 2018 оны ажлын төлөвлөгөөнийн Зорилтын 5,1-д Бүтээгдэхүүн хуваах гэрээг ил тод байдлыг хангахад учирч буй бэрхшээлийг судлан тогтоож, ямар түвшинд ил болгох боломжтой талаар талууд зөвшилцөх гэсэн том зорилт орж ирсэн байна. Бүтээгдэхүүн хуваах гэрээ ямар түвшинд ил болсон талаар тусгасан байна,

энэ ажлыг маш чухал гэж үзэж байна. Энэ ажлыг дагаад хичнээн компани гэрээ байгуулсан, хэд нь гэрээний үүргээ биелүүлсэн талаарх мэдээллийг ил болгож болох уу? Манай байгууллагад гэрээ байгуулсан компанийн 70 орчим хувь нь нөхөн төлбөрөө төлдөггүй, гэрээ цуцлагдсан гэсэн гомдлууд ирдэг. Эхний ээлжинд зарим баримтууд нотлогдоод байгаа. Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотойгоор гэрээний хэрэгжилтийн асуудал гарч ирнэ. Энэ талаарх ажлыг 2018 онд хийж дуусгах уу? Мөн БХГ-тэй холбоотой асуудлыг орон нутаг, төрийн албан хаагчид мэддэггүй, төлбөрөө төлж байгаа компани нь ч ойлгоогүй байдаг. Иймд сургалтын нэг хэсэгтээ бүтээгдхүүн хуваах гэрээний талаар оруулж, ач холбогдлыг иргэд, аж ахуйн нэгжид ойлгуулах нь зүйтэй гэсэн саналтай байна.

Б.Баярмаа: Төлөвлөгөөнд зөвхөн газрын тосны гэрээг ил тод болгох талаар оруулсан байна. Нэгтгэл тайланд 261 компанийн лицензийн огноо байхгүй олдохгүй байна гээд байдаг. Энэ маш аюултай байдал үүсэх гээд байна. Хэзээ олгосон нь мэдэгдэхгүй, хуулийн хэрэгжилт нь олгосон өдрөөс яваад байдаг. Өргөдлийн огноог ил болгох талаар ажил хийх санал байна. Урамшууллын тогтолцоог бий болгох, судалгаа хийх гэсэн ажлыг төлөвлөгөөнөөс хасмаар байна. Гаднын хүмүүс, сургалт хийсэн хүнээс асуусан. Ил тод болгох юмыг хуулиар үүрэг болгож өгчихөөд, хийхгүй бол хариуцлага тооц. Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хуулиа төлөвлөгөөнд тусгаад батлуулах талаар ажилламаар байна. Сургалтуудыг нэгтгэмээр байна, бидний ихэнх мөнгө реклам суртчилгаанд явчихаад байна, асуудлыг шийдэх дээр биш

Д.Эрдэнэчимэг: Санал хэлж байгаа хүн болгон бодлогын асуудлыг ярьж байна. Бид төлөвлөгөөний уриагаа “Тайлагналаас шийдэл рүү” гэдэг ч юм уу засах санал байна. Бодлогын түвшин шийдвэр гарвал нөхцөл байдал сайжраад, сурталчилсан сурталчилаагүй иргэд ойлгох болно. Төлөвлөгөөн дээр цацраг идэвхт бодисын тухай асуудал ороогүй байна, үүнийг оруулах хэрэгтэй байх. Гэрээний ил тод байдлыг хангах чиглэлээр бусад гэрээг ил тод болгох асуудал хангалтгүй байгаа. Бид хэдийгээр санамж бичиг байгуулаад ажиллаж байгаа ч одоогоор 35 хан гэрээг татаж оруулсан байгаа. Гэрээг татаж оруулахад маш их хүндрэл гарч байгаа. Энэ тал дээр Уул уурхайн яам манлайлан ажиллахгүй бол ажлын алба, иргэний нийгэм хүч хүрэхгүй байгаа.

Н.Баярсайхан: Төлөвлөгөөгөө ерөнхийгөөр нь батлая, төсвөө дараа нь эргэж харъя. Тайлангийн зөвлөмж одоо гарч байна, төсвөө ерөнхийгөөр нь батлаад дараа нь хуваарилалтаа хийе. 2019 оноос эхлээд дэд зөвлөлүүд төсөвтэй болох гэж байна. Тэгэхээр төсөв төлөвлөж, захиран зарцуулах ажлыг хэрэгжүүлэх дэд зөвлөл түүнийг чадавхжуулах ажлыг хийх шаардлагатай .

Б.Энх-Амгалан: Ажлын төлөвлөгөөнд гишүүдийн саналыг тусгаснаар төлөвлөгөөгөө батлаж байна. Шийдвэрийн төслийг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү.

3. ХЭЛЭЛЦСЭН НЬ: Ашиг хүртэгч эздийг ил тод болгох замын зураг төлөвлөгөөний төслийн тухай.

Д.Дамба: Та бүхний амар амгалан айлтгая. Ашиг хүртэгч эздийг ил тод болгох замын зургийн төлөвлөгөө боловсруулах дэд ажлын хэсэг байгуулагдсан, үүнийг миний бие ахлан ажилласан. Бид 2016 оны 12 дугаар сард Үндэсний зөвлөлийн хуралдаанаар 7 зорилт 32 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг та бүхнээр батлуулсан. 2017 онд хийхээр төлөвлөсөн 22 ажлаас 13 ажлыг хийж гүйцэтгэсэн, үлдсэн ажлууд хэрэгжих шатандаа явж байна гэж тайлагнаж байна. Тухайлбал, Үндэсний бодлоготой уялдуулах, нөлөөллийн үйл ажиллагаа буюу хэлэлцүүлэг сургалтыг зохион байгуулах, Засгийн газрын холбогдох шийдвэрийг хэрэгжүүлэх гэсэн арга хэмжээнүүдийг хийсэн байна. Хийсэн гол ажлуудыг гишүүдэд тараасан байгаа. 2018 оны төлөвлөгөөнд замын зургийн зорилт, арга хэмжээ нь хэвээрээ, гол нь санхүүжилтийн эх үүсвэргүй, тодорхойгүй байсан асуудлыг тодотгоод, ЕСБХБ ны шугамаар хэрэгжиж байгаа төслийнхөө хүрээнд санхүүжүүлэхээр харилцан тохиролцоод, тодотгол хийсэн байгаа. Үүнд, нэгдүгээр зорилтын хүрээнд төр засгийн байгууллагуудын түвшинд уулзалт, хэлэлцүүлэгийг зохион байгуулах, хоёрдугаар зорилтын хүрээнд холбогдох хуулийн төсөлд өөрчлөлт оруулна, энэ нь манай яамнаас шинээр боловсруулж байгаа хуулийн төсөлд тусгай бүлэг оруулж байгаа, мөн тавдугаар зорилтын хүрээнд олон нийтийн чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд сургалт зохион байгуулахаар зургадугаар зорилтын хүрээнд мэдээллийг баталгаажуулах, систем хөгжүүлэх, сургалт зохион байгуулах чиглэлээр ажиллахаар нийтдээ 205 000 еврогийн төслийг хэрэгжүүлэхээр өөрчлөлтийг оруулсан. Мөн зорилт арга хэмжээний хүрээнд хариуцлага нэмэгдэнэ, итгэлцэл бий болно, авилга буурна, шударга өрсөлдөөн бий болно, бизнесийн үйл ажиллагаа улс төрөөс ангид, илүү тогтвортой, үр дүнтэй байх ач холбогдолтой гэж үзэж байна. /Танилцуулгыг хавсаргав/

Б.Энх-Амгалан: Ашиг хүртэгчийг барьж аваад шийтгэх гээд байгаа асуудал биш, хамгийн гол нь төрд ажилладаг шийдвэр гаргадаг хүн, өөрөө ашиг хүртэгч байж болохгүй гэсэн агуулгаар ил болгох гээд байгаа. Түүнээс биш бизнес эзэмшдэг хүн хэдэн хувиа ч эзэмшинэ вэ хамаагүй, татвараа төлөөд явж байвал болно.

Б.Баярмаа: Хоёр ойлголт байгаа, нэг нь улс төрд нөлөө бүхий этгээд гэж байдаг

Б.Болдбаатар: Тайлан дээр алдаа гарч байсан. Багануур ХК-ны 75 хувь нь улсынх, үлдсэн 25 хувийг бусад хувьцаа эзэмшигчид эзэмшдэг. Тэр нь хэн бэ гэвэл Улаанбаатар банк ч юмуу, Бадамжунай гэх мэт олон хүмүүс яригдаад байдаг, тэр хүмүүс ашиг хүртэгч эзэд мөн үү биш үү? Хэрвээ мөн бол үүнд хамаарах ёстой. Хувьцаат компаниудын асуудал дээр санаа тавиач гэж хэлмээр байна. Энэ талаар 2018 оны төлөвлөгөөнд тусгаж оруулмаар байна.

Д.Дамба. Томъёоллыг нь “төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын” гэж оруулж болно.

Б.Энх-Амгалан: Ашиг хүртэгч эздийг ил тод болгох ажил дээр АТГ илүү хамтарч ажиллах байх.

Б.Тэрбиш: Манай байгууллага энэ талаарх ажлаа эхэлсэн байгаа. Манай судалгаа шинжилгээний алба 6000 гаруй лиценз эзэмшигчийн мэдээлэл дээр тулгуурлаад эхний ээлжинд ашиг хүртэгч байна үү, эцсийн эзэмшигч байна үү эсвэл улс төрд нөлөө бүхий гэх юмуу этгээдийг ил болгох байх. Энэ асуудал өөрөө шинэ тутам учраас энэ талаарх судалгаа, мэдээлэл муу байна. Яагаад гэвэл тусгай зөвшөөрөл эзэмшдэг улс төрийн албан тушаалтан, нийтийн эзэмшлийн ажилтнуудын

судалгаа арай хийгдээгүй, одоогийн байдлаар Эрчим хүчний салбарын судалгаа бүрэн хийгдсэн байна.

Б.Батцэнгэл: Улсын хэмжээнд 3800 орчим Ашиглалтын лицензтэй хүн байгаа. Зарим нөхдүүд хэд хэдэн лиценз эзэмшихээд, зараад байдаг. Хоорондоо гэрээ байгуулсан байдаг ингээд гэрээний үнийн дүнгийн 30 хувийг төлж, шилжүүлдэг. ОУИТБС-ын тайлан өгсөн 2000 орчим компани байна, үлдсэн нь татвар дээр бүртгэлгүй, лиценз эзэмшигч нар байгаад байна. Үүнийг Ашигт малтмалын газар яаж ч чаддаггүй ийм асуудал байдаг. Манай татварын газрынхан лицензийг үнэхээр үнэтэй цайтай эд үү гэдгийг мэдэхгүй, ТЭЗҮ яасан, хайгуулын лицензээ яаж Ашиглалт болгосон байна, үүн дээр улс юу амласан юм бэ? лицензийн асуудал өчнөөн хувирсан байдаг. Тэгэхээр энэ асуудлыг мэргэжлийн байгууллагууд шийдэл гаргамаар байна. 2018 оны 6 сарын дотор ил болгоно гэсэн журам гарсан байна. Заавал төрд ажилладаг биш, ажилгүй энгийн иргэн лиценз зараад яваад байдаг. Лицензийн талаарх асуудлыг АТГ-ын хүмүүс хамтраад ажиллах байх аа.

Б.Дэлгэрмаа: Цар хүрээний хувьд тусгай зөвшөөрөл эзэмшигч дээр нэмээд хөрөнгө оруулагч, баяжуулагч, томоохон компаниудын бүтээгдхүүний авдаг эздийг ил болгоно гэсэн байгаа.

Ю.Дэлгэрмаа: Энэ дээр төрийн байгууллагуудын уялдаа холбоо харагдаад байна.

Б.Тэрбиш: Манай байгууллагаас Уул уурхайн яаманд зөвлөмж хүргүүлсэн байгаа. 2017 онд лиценз олгох ажиллагаа явагдаагүй, цахимаар явагдаж байсан одоо яагаад явахгүй байна зэрэг 10 гаруй асуудал дээр зөрчлийг арилгах чиглэлээр зөвлөмж өгсөн байгаа.

Б.Энх-Амгалан: За асуудлыг сонслоо, гуравдугаар асуудалтай холбогдолтойгоор шийдвэрийн төсөл танилцуулъя. Зөвшөөрч байгаа гишүүд гараа өргөнө үү.

Д.Галбаатар: Цаад санаа нь лиценз эзэмшиж байгаа, хөрөнгө оруулж, байгаа гэсэн санаа байна. Ашиг хүртэгч гэдэг чинь өөр юм, ашиг гэдэг чинь өөр ойлголт.

Д.Дамба: Шийдвэрийн төсөлд ажлын хэсэгт даалгав гэж байна, энэ нь ОУИТБС-ын Ажлын хэсэг үү, дэд ажлын хэсэг бол Замын зураг гаргах ажлын хэсэг байсан. Хэрвээ Уул уурхайн яамнаас хүн байвал хэлтсийн газраас дээш албан тушаалтай хүн байвал, оролцоог хангаж, шийдвэр гаргаж ажиллах боломжтой гэсэн санал байна.

Ш.Цолмон: Ер нь Уул уурхайн бодлогын газрын даргын хариуцан хийж байсан ажил юм. Хуучин дарга нь албан тушаал өөрчлөгдсөн тул Дамба хариуцаад явж байгаа, энэ талаар асуудлыг ЗГХЭГ-аас Уул уурхай хүнд үйлдвэрийн яаманд чиглэл хүргүүлж болох юм.

Д.Эрдэнэчимэг: Манай дэд ажлын хэсгийг ямар журмаар томилж байсан тэр замаар шийдвэл болохгүй юу?

Ш.Цолмон: Өмнө нь Энхбаяр гуай томилсон.

Б.Энх-Амгалан: Тэгвэл дотооддоо шийдэх боломжтой юм байна, Засгийн газрын тогтоол гаргуулна гэвэл хүндрэлтэй байдаг. Дөрөвдүгээр асуудлыг сонсоё.

4. ХЭЛЭЛЦСЭН НЬ: Ашигт малтмалын тухай хуулийн 42-р зүйл, Засгийн газрын 2016 оны 179-р тогтоолын хэрэгжилтийг сайжруулах, Үндэсний зөвлөлөөс чиглэл гаргах тухай.

Н.Баярсайхан: Тайлангийн дүгнэлт дээр гарсан, орон нутаг компанийн төлөөлөл ч ярьж байгаа асуудал бол хамтын ажиллагааны гэрээний асуудал байгаа юм. Ашигт малтмалын тухай хуулийн 42-р зүйлд байгаль орчныг хамгаалах, ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтцийг сайжруулах, үйлдвэрийн үйл ажиллагаа явуулахтай холбоотой асуудлаар гэрээг байгуулна гэсэн хуулийн заалт заавал байгуулна гэсэн байгаа.

Үүний дараа 2016 онд Засгийн газрын 173-р тогтоолоор Хамтын ажиллагааны гэрээ байгуулах загварыг баталж өгсөн, хэрэгжилт гажуудалтай хийгдэж байна. Энэ нь хэрэгжүүлэх журмыг баталж өгөөгүйгээс болж байна. Дорноговь, Өмнөговь, Ховд, Баянхонгор гэх аймгуудын удирдлагууд бүх компаниудтай гэрээ байгуулж байгаа. Энэ сөрөг үр дагавартай байна, аймаг бүх тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулж чадахгүй байна. Энэ талаар иргэд, төрийн байгууллага болон компаниуд бүгд ярьж байна. Аймгийн удирдлагууд бүх компанитай гэрээ байгуулж чадахгүй, зөвхөн томоохон компанитай байгуулж, хөрөнгө төвлөрүүлэх замаар ажиллаж байна. Жишээлбэл, Дорноговь аймгийн Даланжаргалан суман дээр үйл ажиллагаа явуулдаг Чингисийн хар алт гэдэг компани тус суманд гэрээ байгуулаад 300 сая төгрөг өгсөн, үүний тодорхой хувь нь сумандаа үлдэхгүй байна. Бид гэрээгээр үүрэг хүлээгээд, хөрөнгө төвлөрүүлээд байдаг гэсэн асуудлыг тавьж байсан. Аймагтай гэрээ байгуулахаар сумын байгаль орчны асуудлын талаар гэрээндээ тусгахгүй байна, үүнийг сумын иргэд эсэргүүцээд байдаг.

Сумын түвшинд үйлдвэрлэлээс үүсч байгаа тээвэрлэлт, байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлийн гэрээний заалтууд орхигдоод байгаа асуудал байна. Нэгэнт аймаг гэрээ байгуулчихаар сумын Засаг дарга хяналт тавьж чадахгүй байна. Энэ гэрээ батлагдаад хэрэгжсэнээр нийтийн эрхзүйн харилцааг зохицуулж байгаа учраас Захиргааны гэрээ болж байгаа. Захиргааны гэрээ болохын хувьд тухай сумын иргэд байгаль орчны нөлөөлөлд өртөж байгаа сонсох ажиллагааг заавал явуулах болж байгаа. Аймагтай гэрээ байгуулснаар сонсох ажиллагааг огт хийхгүй байна. Дээрх дөрвөн аймагт хийсэн гэрээн дээр сонсох ажиллагаа хийгдээгүй байна. Аймаг хөрөнгө төвлөрүүлээд ТББ-ийн данс, нутгийн зөвлөлийн дансаар багагүй хэмжээний мөнгийг авч байна. Энэ нь авилгын эрсдэлийг нэмэгдүүлж байна, ил тод байдлыг бууруулж байна, засаглалыг муутгаж байна, иргэдийн дундах хардлага сэрдлэгийг улам бий болгож байна, байгаль орчны хариуцлагыг бүрхэгдүүлж байна. Ийм учраас энэ асуудлыг Үндэсний зөвлөлийн хуралд танилцуулж шийдэл гаргая гэж танилцуулж байна. Ер нь Уул уурхайн яам, Улсын Их хурал, Засгийн газраас уул уурхайн салбарыг илүү хариуцлагатай явуулах, ил тод нээлттэй байлгах, байгаль орчинд хал багатай явуулах бодлогуудыг гаргаж байна. Хамгийн гол нь дунд шатандаа буюу аймагт очоод гажуудах, гуйвах, хэрэгжихгүй байх асуудал байна. Ингээд Үндэсний зөвлөлөөс дараах шийдвэрийг гаргуулах саналтай байна.

Засгийн газрын 176-р тогтоолыг хэрэгжүүлэх журам боловсруулах ажлын хэсгийг Уул уурхайн яаман дээр төвлөрүүлэн байгуулах саналтай байна. Үүнийг нэгдүгээр улиралд байгуулах шаардлагатай. Дээрх дурдсан аймгууд гэрээ байгуулсан гэхдээ бүрэн байгуулж чадаагүй сорчлон байгуулсан, байгуулсан гэрээнүүд илт хууль бус байгаа. Хэрвээ шалгавал Засаг дарга нь хариуцлага хүлээх эрсдэл бий болоод байна. иймд гэрээ байгуулсан газруудад АТГ-аас хяналт үнэлгээ хийж, гажуудал байвал засаж залруулах ажлыг АТГ-д өгсөн шийдвэр гаргая гэсэн

саналтай байна. Ингэж ажиллахгүй бол Төрийн албанд ажиллаж байгаа хүмүүсийг эрсдэлд оруулах нь, иймээс урьдчилан сэргийлэх, болгоомжлох үүднээс энэ саналыг оруулж байна.

Б.Энх-Амгалан: Энэ гэрээ нь Засаг дарга ба компаниудын хоорондох асуудлыг зохицуулах гээд байна. Та аймгууд гэрээ байгуулаад дундаас нь мөнгө иддэг асуудлыг болиулах гээд байна гэсэн үг үү?

Н.Баярсайхан. Иддэг гэж хэлэхгүй, тодорхой хөрөнгө төвлөрүүлээд бүтээн байгуулалтын ажил хийж байна гэхдээ бүгдийг аймагт төвлөрүүлээд байна, суманд хөрөнгө очихгүй байна, иргэд эсэргүүцэх гол шалтгаан болж байна. Засгийн газрын загвар гэрээг ашиглахгүй байна, төвлөрүүлсэн хөрөнгийг шууд авч болохгүй учраас карманы ТББ байгуулаад түүний дансаар авч байна, хууль хэрэгжихгүй байна. Загвар гэрээ түүнийг хэрхэн хэрэгжүүлэх нэг мөр ойлголт өгсөн журам, удирдамж гаргаагүйгээс төрийн байгууллагын ажилтан, тодруулвбал аймгийн ЗД нар, компаниуд аль аль нь эрсдэлд ороход бэлэн болоод байна. Ийм асуудлуудын үүднээс тодорхой журам гаргая гэсэн санал байгаа юм. үүний тулд талуудын оролцоотой цомхон ажлын хэсэг гараад, аль болох 1-р улиралдаа багтаад журам, удирдамжийг гаргаж мөрдүүлэх шаардлага байгаа тул энэ асуудлыг оруулж шийдвэр гаргаж өгөхийг хүсч байна.

Б.Энх-Амгалан: Төв аймгийн Засаг дарга аймагт байгуулсан гэрээ байхгүй, сумдын дарга нар гэрээ хийж, хөрөнгө төвлөрүүлж байна гэсэн. Зарим сумдын дарга нар аймгийн Засаг даргадаа захирагдахгүй байдаг асуудал байж болох.

Н.Баярсайхан: Бидний боловсруулсан гэрээний загвар хоёрдмол утгатай байсан байна. Иймээс аймаг, сум аль аль нь байгуулаад байна. Ер нь стратегийн ордод аймаг, сум компани гурвалсан гэрээ байгуулж болно. Харин стратегийн бус бол сум нь байгуулаад, ЗЕХ-ийн дагуу авч үзвэл захиргааны гэрээ болох тул уул уурхайн төслийн сөрөг нөлөөлөлд хамгийн ихээр өртөж буй иргэдийг сонсох ажиллагаагаа яаж явуулах, хөрөнгө яаж төвлөрүүлэх зэрэг асуудлуудыг нарийн заагаад өгчихвөл хянаж болохоор харагдаж байгаа.

Д.Энхболд: Орон нутгийн Засаг захиргаа гэж сум, баг, аймгийг хэлнэ гэдэг. Тэгэхээр компаниуд аль нэгийг нь сонгоод хийчих юм уу гэдэг нь тодорхойгүй байгаа. Загвар гэрээ бэлтгэж байхад Уул уурхайн ассоциаци санал өгч байсан. Гэрээ яах вэ загвар шүүдээ, тэгэхээр гэрээгээ хэрхэн байгуулах вэ гэдэг дагалдах загвар гарын авлага заавар, журам хэрэгтэй гэдэг саналыг гаргаж байсан, хүлээж аваагүй. Санааг нь дэмжиж байна, заавал Үндэсний зөвлөлөөр ярих ёстой юу гэдгийг мэдэхгүй байна.

Д.Галбаатар: Энэ чинь хандивын асуудал биз дээ.

Н.Баярсайхан: Хандив бишээ

Д.Дамба: Дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль хамгаалах, ажлыг байр нэмэгдүүэх гэсэн гурван чиглэлээр гэрээ байгуулах боломжтой.

Б.Баярмаа: Ашигт малтмалын газар дээр ажлын хэсэг ажиллуулна гэж яригдсэн.

Н.Баярсайхан: тэр нь одоогоор байхгүй байна.

Д.Галбаатар: Орон нутгийн дарга бодитой юм ярьсан, түүнийг анхаармаар байна.

Н.Баярсайхан: Аймаг, сум, баг бүгд нутгийн захиргаа, Тиймээс загвар гэрээг боловсруулах шатанд бүх талуудын удаа дараагийн хэлэлцүүлгээр ярилцсаар байгаад стратегийн ордод аймаг гэрээ байгуулна гэж зааглаж, тодорхой болгож оруулсан санаатай. Гэвч энэ нь хангалтгүй байна. Бид чиглэл өгөөгүй учраас хуулийг гажуудуулах, эрсдэлийг бий болгох, компанийн үйл ажиллагаанд саад болоод байна. Дорноговь аймаг гэхэд хамтын ажиллагааны гэрээ байгуулаад хэдэн төгрөг төвлөрүүлэх гэдгээ тусгасан байгаа. Гэтэл тэр мөнгөө өгөхгүй бол лицензийг нь цуцална гэж заалт бүхий гэрээ байна, ийм байж болохгүй, тодорхой журмыг гаргаж өгөх хэрэгтэй

Д.Дамба: Ерөнхий сайд Үндэсний зөвлөл ахлаж байгаагийн хувьд эрхэлсэн сайддаа чиглэл өгөөд, гэрээний загвараа шинэчлээд, хавсралтаар аргачлалыг нь батлах нь зүйтэй байх. Орон нутгийн засаг захиргаа гэж үүнийг хэлнэ гэж заагаад өгөх хэрэгтэй.

Д.Галбаатар: Орон нутгийн дарга гоё санаа хэлсэн, та нар зорилго зорилт дэвшүүлээд байгаа бол тэр чинь хэмжигдмээр байна гэж. Хэмжигдэх нэгж нь өмнө нь мөнгө байсан, нөөцийн төлбөрийн 20 хувийг аймагт, 10 хувийг суманд үлдээх зохицуулалт хийх шаардлагатай. Тэгэж чадвал энд яригдаад байгаа бүх асуудал шийдэгдээд явчихна. ААН-үүд төлбөрөө төлнө, авсан төлбөрөө ИТХ хувиарлана.

Б.Энх-Амгалан: Таны энэ асуудал 2018 оны төлөвлөгөөнд тусгагдсан уу?

Н.Баярсайхан: үгүй, гэхдээ Уул уурхайн яаманд чиглэл, үүрэг өгчихвөл болно.

Б.Энх-Амгалан: Би нар Уул уурхайн яаманд үүрэг өгдөг статус биш. Харин энэ асуудлыг анхааралдаа авна уу, анзаарч харна уу гэх мэтээр хандах ёстой.

Н:Баярсайхан: Тэгвэл гурван талт ажлын хэсэг байгуулъя.

Б.Энх-Амгалан: ажлын дэд хэсгээр гаргасан шийдвэр нь Уул уурхайн яаманд зөвлөмж болж очих уу?

Н. Баярсайхан: Журмыг Уул уурхайн яамны сайдын тушаалаар батлаж болно.

Д.Эрдэнэчимэг: Санаачилгыг хэрэгжүүлж буй ихэнх ажил Уул уурхайн яамтай хамтран хийж буй ажлууд юм. Тухайлбал, гэрээний ил тод байдлын ажлын хэсэг, Ашиг хүртэгч эздийн ажлын хэсэгт ажиллаж байсан.

Б.Энх-Амгалан: Талуудаас ажлын хэсэгт орох хүн байна уу? Иргэний нийгмийн төлөөлөл хоёр хүн сонголоо, төрийн байгууллага, иргэний нийгмийн төлөөллийг санал оруулах байх.

Д.Галбаатар: Үйлдвэрийн төлөөлөл болсон бид хэд ярилцлаа, хуучин хуульд байсан 20,10 гэсэн хувиа сэргээгээд өгөөч гэсэн саналтай байна.

Б.Энх-Амгалан: За, дэд хэсгийг УУХҮЯ-ны уул уурхайн бодлогын газрын даргаар ахлуулан байгуулья. Иргэний нийгмээс Баярсайхан, Эрдэнэчимэг нар орно. Бусад талуудаас 2 хүний нэр өгөөрэй гэж шийдлээ шүү. За одоо, сүүлчийн асуудлаа сонсьё.

5. ХЭЛЭЛЦСЭН НЬ: Үндэсний зөвлөлийн ажиллах журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай.

Ш.Цолмон: ОУИТБС-ын Удирдах хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу нэмэлт өөрчлөлтийг оруулж байна. Энэ асуудлыг ажлын хэсгийн хуралдаанд танилцуулж байсан. Зөвлөмжийн дагуу журамд дараах нээлт өөрчлөлтийг оруулах саналтай байна. Үүнд, Ажлын хэсгийн нийт гишүүдийн тоо 33 буюу оролцогч тал бүр тэнцүү 11 төлөөлөлтэй байдаг. Хуралдаанд ирсэн байвал зохих гишүүдийн тоог оролцогч бүрээс 6 гишүүн ирсэн байвал хуралдааныг хүчинтэйд тооцох саналыг оруулж байна. Өөрөөр хэлбэл, 3 тал бус бүр 6 хүн буюу нийт 18 гишүүн байхаар санал болгож байв. Өмнө нь 16 байхад ирц гүйцсэнээр тооцож ирснийг ингэж өөрчлөх саналтай байна. Зөвлөмжийн дагуу шийдвэр гаргахад санал зөрөлдөх тохиолдолд санал хураах боломжийг нээж байгаа бөгөөд үүгээр санал хурааж, шийдвэрийн хүчинтэй байх дүн нь тухайн асуудлаар хуралдаанд оролцсон төлөөлөл бүрийн 2/3-оос доошгүй тооны гишүүдийн санал авсан байх ёстой гэсэн өөрчлөлтийг оруулах саналтай байна.

Б.Энх-Амгалан: Миний хувьд ОУИТБС-ын хуралд 3 дахь удаагаа сууж байна. Ерөнхий сайдын хэлснээр зөвд зөөлөн, бурууд хатуу байх зарчмыг барина. Буруу үйлдэл хийгээд байгаа, хууль дүрэм зөрчөөд байгаа хүмүүсийг хэлээрэй, арга хэмжээ авхуулж ажиллах болно. Энэ журам бол аятайхан журам байгаа, энэ үзэл санаагаар журам орж ирсэн. Нөгөө талдаа компанийн эрх ашгийг тэнцүү харж үзэх ёстой. Төр засгийн үүрэг гэвэл зохицуулах юм. Шаардлагатай тохиолдолд, тухайлбал тухайн орон нутгийн иргэдийн, улс орны хэмжээнд нэн шаардлагатай томоохон хөрөнгө оруулалт, бүтээн босголт байвал Засгийн газар дэмжинэ, шийдвэртэй арга хэмжээг авна.

Б.Болдбаатар: Уул уурхайн мэргэжлийн холбоод болон компаниудын төлөөллийг Уул уурхайн ассоциаци томилж байна, энэ нь ил тод биш байна.

Хуралдааны шийдвэрийн төслийг Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Энх-Амгалан уншиж танилцуулан, гишүүд 100 хувь дэмжиж батлав.

Б.Энх-Амгалан: Хуралдаанд идэвтэй оролцсон, цаг заваа гаргасан та бүхэнд баярлалаа, амжилт хүсье.

Хуралд 19,10 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ажлын албаны дарга бөгөөд
ахлах зөвлөх, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн
нарийн бичгийн дарга,
ажлын хэсгийн ахлагч



Б.Энх-Амгалан

Тэмдэглэлийг хянасан:

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга,
ажлын албаны зохицуулагч



Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн
ажилтан



А.Отгонтунгалаг

МОНГОЛ УЛСЫН ОУИТБС-ЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН 16 ДУГААР ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ- Д

Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн 16 дугаар хуралдаан Төрийн ордны “Нутгийн удирдлагын танхим” 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 15.00 цагт эхлэж 19.00 цагт дуусав.

- I. **Хэлэлцсэн нь:** Монгол, Францын “КэйПиЭмЖи” компаниудын консорциумын боловсруулсан Монгол Улсын ОУИТБС-ын 2016 оны буюу 11 дүгээр нэгтгэл тайлан:

Шийдвэрлэсэн нь:

1. Монгол, Францын “КэйПиЭмЖи” аудитын консорциумын боловсруулсан Монгол Улсын ОУИТБС-ын 2016 оны буюу 11 дүгээр нэгтгэл тайланг зарчмын хувьд батлахаар тогтов.
2. Монгол Улсын 2016 оны тайланг оролцогч бүх талууд өөрсдийн цахим хуудаст байрлуулах, Ажлын албанаас хураангуй хувилбарыг нийтэд ил тод болгож, сурталчлах нь зүйтэй гэж үзэв.
3. Монгол Улсын 2016 оны тайлан, 2017 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагаа, ахиц дэвшлийн тухай тайлан, 2018 оны ажлын төлөвлөгөөтэй хамт ОУИТБС-ын олон улсын удирдах хороонд 2017 оны 12 дугаар сарын 31-ний дотор хүргүүлэхийг Ажлын албанд даалгав.
4. Тайлангаар өгөх зөвлөмжүүдээ нарийвчилж, тодорхой болгох, тайланг хэл найруулгын хувьд засч сайжруулан, гишүүдээс гаргасан саналыг харгалзан тусгаж 2018 оны 1 дүгээр сарын 15-ны дотор эцэслэн Ажлын албанд хүлээлгэж өгөхийг Монгол, Францын “КэйПиЭмЖи” аудитын консорциумд аалгав.
5. Энэхүү тайлан, Үндэсний зөвлөлийн 16-р хуралдааны талаар нийтэд мэдээлж ажиллахыг Засгийн газрын Хэвлэл мэдээллийн алба, Ажлын албанд даалгав.
6. Гэрээт ажлын үлдэгдэл мөнгийг “КэйПиЭмЖи” аудитын консорциумд төлж барагдуулахыг Ажлын албанд зөвшөөрөв.
7. Монгол Улсын 2016 оны тайлан болон тайлан гаргаагүй, аудитын явцад нэмэлт мэдээлэл гаргаж өгөөгүй байгууллагуудад хариуцлага тооцох тухай асуудлыг УИХ-ын Эдийн засгийн, Төсвийн байнгын хороо, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Ажлын албанд даалгав.
8. Үндэсний зөвлөлийн ээлжит бус хуралдааныг 2018 оны эхний улиралд багтаан зохион байгуулж, ОУИТБС-ыг хэрэгжүүлэхтэй холбогдсон бодлогын асуудлыг хэлэлцэхээр тогтов.

- II. **Хэлэлцсэн нь:** Монголын ОУИТБС-ын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн тухай:

Шийдвэрлэсэн нь:

1. Монголын ОУИТБС-ын 2017 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2018 оны ажлын төлөвлөгөөтэй танилцаж, гишүүдээс гаргасан саналын хамт батлав.
2. Монголын ОУИТБС-ын 2017 үйл ажиллагаа, ахиц дэвшлийн тухай тайланг гишүүдийн саналыг тусган батлахаар тогтов.
3. Ахиц дэвшлийн тайланд Компани, Иргэний нийгмийн товч танилцуулгыг 12 дугаар сарын 28-наас өмнө Ажлын албанд ирүүлэхийг Монголын Уул уурхайн үндэсний ассоциаци, Иргэний нийгмийн “Төлсөн авснаа нийтэл” эвсэл, Монголын байгаль орчны иргэний зөвлөлд санал болгов.
4. 2017 оны ажлын төлөвлөгөөнөс хийгдээгүй ажлуудыг 2018 онд хэрэгжүүлж, явцыг Ажлын хэсэгт хагас жил бүр танилцуулж байхыг Ажлын албанд даалгав.

5. ОУИТБС-ын орон нутаг дахь хэрэгжилтийг хангаж, үр нөлөөг тухай бүр тайлагнаж байх үүргийг Аймгийн засаг дарга нарын 2018 оны үр дүнгийн гэрээнд тусгаж ажиллахыг Ерөнхий сайдын ажлын албанд даалгав.

III. Хэлэлцсэн нь: “Ашиг хүртэгч эцсийн эздийг ил тод болгох замын зураг-2020 он” төлөвлөгөөний биелэлтийн явц, нэмэлт өөрчлөлтийн тухай:

Шийдвэрлэсэн нь:

1. “Ашиг хүртэгч эцсийн эздийг ил тод болгох замын зураг-2020 он” төлөвлөгөөний биелэлтийн явц, шинэчилсэн төлөвлөгөөг гишүүдийн саналыг тусган батлахаар тогтов.
2. Төлөвлөгөөний биелэлтэд улирал бүр хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсэгт даалгав.

IV. Хэлэлцсэн нь: Ашигт малтмалын тухай хуулийн 42-р зүйл, Засгийн газрын 2016 оны 179-р тогтоолын хэрэгжилтийг сайжруулах, Үндэсний зөвлөлөөс зөвлөмж чиглэл гаргах тухай:

Шийдвэрлэсэн нь:


1. Үндэсний зөвлөлөөс өгөх зөвлөмжийг боловсруулах Ажлын дэд хэсгийг УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газрын дарга Ж.Ганбаатараар ахлуулан байгуулахаар шийдвэрлэв.
 2. Бүрэлдэхүүнд оролцогч тал бүрээс 2 хүн байхаар тогтов.
 3. Иргэний нийгмийн төлөөллөөс “Төлсөн авснаа нийтэл” эвслийн зохицуулагч, Нээлттэй нийгэм форумын менежер Д.Эрдэнэчимэг, “Хил хязгааргүй алхам” ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан нар өөрсдийн саналаар бүрэлдэхүүнд орохоор болов.
- V. Хэлэлцсэн нь:** Үндэсний зөвлөлийн ажиллах журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай:

Шийдвэрлэсэн нь:

Үндэсний зөвлөлийн ажиллах журамд нэмэлт өөрчлөлтийг гишүүдийн саналыг үндэслэн батлахаар тогтов.

Тэмдэглэлтэй танилцсан

Ерөнхий сайдын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч



Б.Энх-Амгалан

Тэмдэглэл хөтөлсөн

ОУИТБС-ын Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн ажлын албаны зохицуулагч



Ш.Цолмон

Санхүүгийн ажилтан



А.Отгонтунгалаг